



# СОЁМБО



БАТЛАН ХАМГААЛАХ, ЗЭВСЭГТ ХҮЧНИЙ ТӨВ ХЭВЛЭЛ

2020.08.27 №33 (10710)

Үнэ 500 төгрөг

Дугаар эрхэлсэн ахлах дэслэгч М.МӨНХЗОРИГ

## ТЭНГЭР НЬ ЦЭЛМЭГ ГАЗАРДАЛТ НЬ ЗӨӨЛӨН БАЙЛАА



Гэрэл зургийг ахлах ахлагч Г.БАТ-ЭРДЭНЭ

(Энэ тухай сурвалжилгыг IV нүүрнээс уншина уу)

### БАТЛАН ХАМГААЛАХЫН САЙД Г.САЙХАНБАЯР ЗЭВСЭГТ ХҮЧНИЙ 186 ДУГААР АНГИД АЖИЛЛАЛАА

Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Батлан хамгаалахын сайд Г.Сайханбаяр Дайчилгаатай команд штабын хээрийн сургуулийн төгсгөлийн шатны тактикийн хээрийн сургуульд оролцсоны дараа Зэвсэгт хүчний 186 дугаар ангид үргэлжлүүлэн ажиллалаа. Батлан хамгаалахын сайдыг тус ангид хүрэлцэн ирэхэд Хүндэт харуул жагсаж угтсан юм. Сайдыг дагалдан Зэвсэгт хүчний Жанжин штабын дарга, хошууч генерал Д.Ганзориг, Зэвсэгт хүчний Хуурай замын цэргийн командлагч, бригадын генерал Б.Амгаланбаатар, Батлан

дээшлүүлэхэд авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээ, өвөлжилтийн бэлтгэл ажил зэргээр мэдээлэл өгөв. Үүний дараа Батлан хамгаалахын сайд Г.Сайханбаяр ангийн бие бүрэлдэхүүнтэй уулзах үеэрээ "Юуны өмнө Дайчилгаатай команд штабын хээрийн сургуулийн бэлтгэл ажлыг хангаж, үүргээ амжилттай гүйцэтгэсэн та бүхэнд чин сэтгэлээсээ талархсанаа илэрхийлье. Тус сургууль иргэдэд эх орноо батлан хамгаалах үүргийг нь ухамсарлуулсан маш үр дүнтэй сургууль болж чадлаа. Сургуульд оролцсон бэлтгэл үүрэгтнүүд



хамгаалах яамны Стратегийн бодлого, төлөвлөлтийн газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч, хурандаа С.Ганбямба нарын албаны хүмүүс ажилласан юм.

Зэвсэгт хүчний 186 дугаар ангийн захирагч, хурандаа Д.Жигжидсүрэн "Дайчилгаатай команд штабын хээрийн сургуулийг зохион байгуулалцахад ангийн офицер, ахлагч, ажилтан албан хаагчид хэдэн сарын өмнөөс л идэвхийлэн зүтгэсэн. Энэхүү зүтгэлийн үр дүнд сургууль ч амжилттай явагдсан" гэдгийг уулзалтын эхэнд онцлоод ангийн ололт амжилт, бэлэн байдлыг

"Бид энэ үүргээ мартсан байжээ. Үүргийг минь ойлгуулсан Зэвсэгт хүчинд баярлалаа. Аймаг бүрт ийм сургуулийг жил бүр алгасахгүй зохион байгуулбал тун сайн сан" гэж хэлж байна. Энэ бол иргэдийн сэтгэгдэл. БХЯ, ЗХЖШ-ынхны үндсэн гол зорилгуудын нэг нь Монгол Улсын иргэдийг эх орноо батлан хамгаалах байнгын бэлтгэлжилтэй болгох юм. Сургуулийн удирдлагуудын илтгэлийг сонсож байхад нийгэмд энэ хэрэгцээ, шаардлага маш их байгаа бөгөөд иргэдийн эх орноо гэсэн чин сэтгэл ч дүүрэн байгаа нь харагдаж байна.

(Үргэлжлэл нь II нүүрт)

### МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД ДАЙЧИЛГААТАЙ КОМАНД ШТАБЫН ХЭЭРИЙН СУРГУУЛИЙГ ӨНДРӨӨР ҮНЭЛЭВ



Дайчилгааны тухай хууль, Монгол Улсын Засгийн газрын тогтоолын дагуу Орхон аймагт дайчилгаатай команд штабын хээрийн сургууль зохион байгуулагдлаа. Тус сургуульд дайчилгааны даалгаварт заагдсан цэргийн бэлтгэл офицер, ахлагч, түрүүч, байлдагчид болон тодорхой тооны техникүүдийг татан оролцуулж,

дайчилгааны бэлтгэл үүрэгтнүүдтэй хүн нэг бүрийн бэлтгэл, салаа, салбарын жигдрэлтийн сургалт, дадлагыг төлөвлөгөөний дагуу явуулсны дараа мотобуудлагын ротын тактикийн хээрийн сургуулийг Зэвсэгт хүчний 186 дугаар ангийн хээрийн сургалтын төвд явууллаа.

(Үргэлжлэл нь III нүүрт)

### ҮНДЭСНИЙ БИЧГИЙГ ТҮГЭЭН ДЭЛГЭРҮҮЛЭХ СУРГАЛТ ХОЁР ДАХЬ ЖИЛДЭЭ ...

Монгол бичиггүй хүн гадаад хэл сурвал бусдын соёлыг сохроор дуурайсан, "буруу номтон" болох өндөр магадлалтай. ҮБХИС-ийн харьяа сургуулиудынхаа хүрээнд "Монгол хэл, бичгийн тэмцээн"-ийг 2014 оноос хойш жил бүр уламжлал болгон зохион байгуулсаар ирсэн. Дээрх уралдаан нь алдаагүй зөв бичигтэн, хичээнгүй цэвэр бичигтэн, компьютероор алдаагүй шивхэ, таталган бичиг унших,

уран бичлэг гэсэн таван төрлөөр явагддаг. Тэмцээнд өндөр амжилт үзүүлсэн оролцогчдыг Зэвсэгт хүчний Жанжин штабын даргын тушаалаар компьютерийн монгол бичгийн сургалтад хамруулдаг уламжлалтай. Салбар сургуулиудын ажилтан, алба хаагч гэлтгүй бусад анги, байгууллагаас ч сургалтад хамрагдах боломжтой аж. Жишээлбэл, тус тэмцээнд Зэвсэгт хүчний 084 дүгээр ангийн ахмад Д.Мөнх-Өнөр хоёр

жил дараалан тэргүүн байр эзэлсэн учир шагналын журмаар сургалтад хамрагдсан байна.

Энэ удаагийн компьютерын монгол бичгийн сургалтыг Улсын онцгой комиссын шийдвэр шаардлага, зөвлөмж дор явууллаа.

Хоёр дахь жилдээ амжилттай явагдсан энэхүү сургалтыг Үндэсний батлан хамгаалахын их сургуулийн багш, профессор Д.Болд удирдсан юм. (Үргэлжлэл нь II нүүрт)

ЦЭРГИЙН ТӨВ ЭМНЭЛЭГ-100 ЖИЛ

## ДОТРОО ТУСГААРЛАЖ, ГАДНАА ТОХИЖИЖ БАЙНА

Цар тахлын хурцадмал байдлын үед Цэргийн төв эмнэлэг халдвараас урьдчилан сэргийлэх, ажиглалт, тандалт хийх, хяналт тавих гол эмнэлгүүдийн нэг болоод буй. Тус эмнэлгийн хувьд өнгөрөгч 3 дугаар сарын 15-ны өдрөөс үйл ажиллагаагаа бүрэн зогсоож тусгай дэглэмд шилжин өсөн давхар эмнэлгийн байраа бүрэн чөлөөлсөн юм. Анхнаасаа халдвараас сэргийлэх, тусгаарлах, хяналт тавих чиг үүрэгтэй байгаагүй ч эмнэлэг дотроо эмнэлэг байгуулан бүсчилж, зохион байгуулалтын өндөр захирал шилжүүлэн өөрсдийн хүчээр өдий дайны болгож чаджээ. Богино хугацаанд өндөр зохион байгуулалтад орсон нь цэргийн албаны нэг онцлог ч гэмээр.

Орж гарах бүх хаалганы харуул хамгаалалтыг чангатгаж, шалган нэвтрүүлэх байраар дамжин өнгөрч байгаа иргэдийн халууныг хэмжиж, гарыг нь ариутгаж, "Амны хаалтаа зүүгээрэй" гэсэн шаардлагыг

байнга тавьж, ягштал мөрдүүлж ажилладаг юм байна. Иргэд ч зүгээр нэг сэлгүүцэж яваагүй гэдгээ ухамсарлаж, олон дуншуулалгүйгээр шаардлагыг хүлээж авна. Үнэхээр ч эмч, эмнэлгийн ажилтан болон иргэд хоорондын итгэлцэл, бие биеэ хүндэтгэх, харилцан шүтэлцээтэй байдал чухал. Энэ үед бүр ч чухал шаардлагатай.

Цэргийн тэв эмнэлгийн удирдлагууд гаднын улс орнуудаас зөвөөрлөгдөн ирсэн иргэдээс эмнэлгийн тусламж, үйлчилгээ шаардлагатай 800 гаруй хүнийг хүлээн авч халдварын урьдчилан сэргийлэлт, ажиглалт, тандалт хийн хяналт тавьж ажилласан гэх сүүлийн үеийн тоон мэдээг өгсөн. Ингэхдээ биеийн байдал маш хүнд өвчтөнд амь тэнссэн үеийн тусламж үйлчилгээ, геомодиализ эмчилгээ, дурангаар улаан хоолойн стент тавих ажилбар, мэс заслын эмчилгээ, мэс ажилбар, боолт, жирэмсний хяналт, хавдрын хими эмчилгээ зэрэг 22 нарийн мэргэшлийн тусламж,

үйлчилгээ үзүүлсэн гэдгийг ч цухас дурдаад өнгөрлөө. Энэ цаг үед та бидний ойлголт Цэргийн төв эмнэлэгт эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ шаардлагатай иргэдийг тусгаарлаж байна гэсэн ерөнхий дур зургаас хэтрэхгүй аж. Гэтэл коронавирусын 25 тохиолдлыг илрүүлж, тэдгээрийг ХӨСҮТ-д шилжүүлээд байгаа гэдгийг удирдлагууд нь учирлаж байна лээ. Тиймээс тус эмнэлгийнхнийг эрсдэл бүхий нөхцөлд ажиллаж байгаа гэхэд үнэнээс хол зөрөөхөөгүй санагдана.

Энд 240 гаруй эмч, сувилагч, эмнэлгийн ажилтнууд тодорхой цагийн хуваарь гарган ажилладаг. Дээрх тоонд мэдээж гал тогоо, инженер, сантехникийн ажилтнууд ч багтаж байгаа. Тэдний хүн нэг бүртэй нь уулзаад "Албандаа хоёргүй сэтгэлээр зүтгэж, сайн ажиллаж байгаа шүү. Баярлалаа" гэж хэлэх завшаан тэр бүр тохиохгүй, цаг хугацаа ч давчуу тул эмнэлгийн удирдлагын зүгээс талархсанаа илэрхийлж дээрх үгийг ажилтан, албан хаагчдадаа

дайж байсныг энд уламжлая. Бурхан хүнийг бүтээж бусдыг нь инженер бүтээсэн гэдэг шиг тэдний ачаар л эмнэлгийн үйл ажиллагаа доголдолгүй хэвийн үргэлжилдэг. Алдар гавьяаны ард нь үлддэг атлаа "хариу нэхдэггүй" тэдгээр хүмүүст бид цаг ямагт талархах нь зүйн хэрэг.

Цар тахлын хурцадмал байдлыг боломж болгон харуулсан жишээ энд бас бий. Гурван давхар эмнэлгийн байрандаа поликлиник буюу амбулаторийн үйлчилгээг явуулахаас гадна мэс заслын эмч нар эмнэлгийн байрны тохижилт, засвар үйлчилгээний ажилд сайн дураараа нэгдсэн гэнэ. Мөн Цэргийн төв эмнэлгийн ар талын хангалт хариуцсан орлогч дарга, дэд хурандаа О.Нарандулам шалган нэвтрүүлэх байрыг шинэчлэн засварлаж байгаа тухай сонсголонтой мэдээг ч дуулгасан. Тогтмол хийгддэг урсгал засвар болов уу гэтэл арай л өөр дүр зураг утглаа. Шалган нэвтрүүлэх байрыг бүрэн шинэчлэн засварлахын зэрэгцээ

бүр угаалтуур, суултууртай буюу бохир цэврийг нь шийджээ. Энэ мэтчилэн жишиг болохуйц олон ажил амаргүй цаг үед энд өрнөж байх юм. Сайн мэдээ энд хүрээд зогссонгүй, хүүхдийн тасаг болон мэдрэлийн тасгийн эмч нарын талаар ч дуулгах сонин хачинтай. Эх нялхсын эрүүл мэндийн төвийн эрчимт эмчилгээний тасагт эх хүүхдийн тасгийн эмч, ажилтнуудаа чадавхжуулах сургалтад хамруулсан бол мэдрэлийн тасгийн эмч нараа Гурвдугаар эмнэлгийн харвалтын тасагт ажиллуулан, харилцан туршлага судлуулж байгаа гэхчлэн асуудал дундаас боломж урган гардгийг харуулсан олон ажлыг энд нэрлэх болохоор. Нөгөөтэйгүүр боловсон хүчнээ чадавхжуулах асуудал хэзээд орхигддоггүй нь дээрхээс харагдана лээ. Дотроо тусгаарлаж, гаднаа тохиож буй зуун жилийн түүх, зузаан намтартай эмнэлгийн завгүй өдрүүдийн талаар цухас өгүүлэхэд ийм буюу. Энэ талаар хожим дэлгэрэнгүй сурвалжилна.

МЭНДЭЛСНИЙ 100 ЖИЛИЙН ОЙ

## ЗУУНД МӨНХӨРСӨН ГЕНЕРАЛ



буйгаа хөндөн хэлсэн.

ШУА-ийн Түүх, археологийн хүрээлэнгийн салбарын эрхлэгч, доктор, профессор, бэлтгэл хурандаа Г.Мягмарсамбуу "Ж.Цэнд-Аюуш бол Чөлөөлөх дайны хүнд бэрхийг нуруун дээрээ үүрч явсан Монголын эрэлхэг зоригтой хөвгүүдийн нэг юм" гэдгийг илтгэлийнхээ оршилд онцлон тэмдэглэв. Тэрээр үргэлжлүүлэн "Чөлөөлөх дайнд МАХЦ-ийн оролцоог 8 дугаар сарын 9-ны өдөр эхлээд 9 дүгээр сарын 3-ны өдрийн ялалтаар дууссан биш, Тэмсэгбулга, Баянтүмэнд байсан анги, салбарууд 7 дугаар сарын эхээр байнгын байрлалаас хэч хуралдуулах районд марш үйлдэж эхлээд 10 дугаар сарын 15-ны өдөр байнгын байрлалдаа буцаж ирсэн. Тийм учраас Чөлөөлөх дайны түүхийг энэ 3 сарын хугацаанд авч үзэх ёстой. Үзэл суртлын хоёр системийн хоорондын дайн байсан учраас цэргийн улс төрийн ажилтнуудын гүйцэтгэсэн үүрэг өндөр байсан. Тэд зөвхөн цэрэг, дарга нартай ажиллаад зогсохгүй, чөлөөлөгдсөн нутгийн ард иргэдийг ухуулан таниулах ажил зохиож байсан. Тэдний нэг нь гарцаа байхгүй 5 дугаар дивизийн 28 дугаар хорооны намын товчооны даргаар оролцож явсан хошууч генерал Ж.Цэнд-Аюуш юм" гэв.

Генералын нарийн бичгийн дарга асан, чөлөөнд байгаа дэд хурандаа Х.Сүхээ гуайн дурсамж сонирхолтой байсан. Тэрээр "Ж.Цэнд-Аюуш дарга хатуу мөртлөө зөөлөн, зөөлөн үү гэтэл хатуу хүн байлаа. Хүнийг загнаж байхыг хараагүй, тэгсэн мөртлөө хүмүүс их хүндэлдэг, бас эмээдэг байв. Яамны сайд, дарга нар аливаа асуудалд Улс төрийн газрын даргын үгийг заавал сонсож байж шийдвэр гаргадаг, нөлөө бүхий удирдагч байсан" гэлээ. Цэргийн Улс төрийн газрын залгамж болж яваа Иргэн-цэргийн харилцааны хэлтсийн дарга, хурандаа С.Төмөрхуяг түүхэн генералын үйл хэргийг өнөөгийн цэргийн алба хаагчдад танилцуулах, дурсгалыг нь мөнхжүүлэхэд дэмжлэг үзүүлж ажиллахаа илэрхийлсэн.

Армийн намын комиссын даргаар ажиллаж байсан чөлөөнд байгаа хурандаа Г.Буянхишиг дурсахдаа "Ж.Цэнд-Аюуш генералын ажлыг хөнгөлөх

гэж Архангай аймагт Намын хорооны нэгдүгээр даргаар томилсон. Айлын нохой буудаж, бүрхээр хэмхэлдэг дарга нарын нэг ирвэ үү гэж эмээж байтал аядуу зөөлөн хэрнээ ажил хэрэгч хүн байж аймаг нь социалист уралдаанд тэргүүлсэн" талаар ч сонирхуулсан. Түүнчлэн генералын санаачлан эхлүүлсэн аймаг, орон нутагт Арми сурталчлах өдрүүд өдгөө ч иргэн-цэргийн харилцааг бэхжүүлэх өгөөж арвинтай ажил болж үргэлжилсээр байгааг бэлтгэл хурандаа Б.Жуваа хэлсэн үгэндээ онцлов.

Ойн баярт оролцогсдын дунд генералын халамж, анхаарал дунд өсөж өндийсэн хүн нэлээд байсан. Тухайлбал, төрсөн ахынхаа өнчин хүүхдүүдийг өөр дээрээ авч гарыг ганзаганд хөлийг нь дөрөөнд хүргэжээ. Генералын гэргий Ш.Буянбат сайхан сэтгэлтэй эмэгтэй байв. Аав, ээжээсээ хагацсан өөрийн шавийг ам бүлдээ авч өсгөсөн нь хожим Москвад Ломоносовын Их сургуулийг дүүргэж, "Үнэн" сонины нэгдүгээр орлогч эрхлэгчээр ажилласан нэрт сэтгүүлч Ц.Мишигдорж гуай бөгөөд тэрээр генералаар овоглодог ажээ.

Энэхүү өнөр гэр бүлд өсөж, ардын хүүхдүүдийг сурган хүмүүжүүлэх мэргэжил эзэмшсэн Ц.Даариймаа Өвөрхангай аймгийн Хархорин суумаас гэр бүлийн хамт ирж, мөнх бусыг үзүүлээд хагас зуун жил өнгөрсөн ч мартагдаагүй, ач буян нь дэлгэрэн буй буурал генералыг дурсаж сэтгэлийн үгээ хэлэв.

Генералын өргөмөл охин Т.Дашпунцаг аавынхаа мэндэлсний 100 жилийн ойг тэмдэглэхэд санаачилга, зүтгэл гаргасан байгууллага, хамт олонд талархал илэрхийлээд хошууч генерал Ж.Цэнд-Аюушийн ажил албаны түүхэн агшныг харуулсан гэрэл зургийн цомгийг Монгол цэргийн музей сан хөмрөгт шилжүүлээ. Ийнхүү зууны манлай генералуудын нэг, төр, цэргийн нэрт зүтгэлтэн, хошууч генерал Ж.Цэнд-Аюушийн мэндэлсний 100 жилийн ойг Монгол цэргийн түүхэнд шашдирласан тулалдаануудын нэг Жанчхүүгийн давааны бэхлэлтийг эзэлсэн 75 жилийн өмнөх ялалтын их уухайтай Даширлуулан ёслол тэмдэглэв. **Бэлтгэл хурандаа Г.НЯМДОРЖ**

## БАТЛАН ХАМГААЛАХЫН САЙД Г.САЙХАНБАЯР ЗЭВСЭГТ ХҮЧНИЙ 186 ДУГААР АНГИД АЖИЛЛАЛАА

(Түрүүч нь I нүүрт)

Өөрөөр хэлбэл, нийгмийн янз бүрийн салбарт ажиллаж байгаа бэлтгэл үүрэгтнүүд өөрийн эрхэлж буй ажил, хөдөлмөрийнхөө хажуугаар эх орноо хамгаалах нэн тэргүүний үүргээ ухамсарлаж чадсан нь хамгийн чухал үр дүн. Сургуулийн явцаас харахад цэргийн бэлтгэл үүрэгтнүүдийн ур чадвар, зэвсэг, техникээ эзэмшиж буй байдал нь нэлээд цэгцэрсэн байна лээ. Удирдсан дарга нь ч "Их богино хугацаанд сэргэлт авсан" гэж хэлсэн. Дээрээс нь Зэвсэгт хүчний 186 дугаар ангийнхан сургуулийн бэлтгэл ажлын хүрээнд зэвсэглэл, техникүүдийнхээ бэлэн байдлыг хангаж, нэлээд ажил хийсэн нь ч харагдаж байна. Ерөнхий сайд У.Хүрэлсүх энэхүү сургуулийг цаашдаа жил бүр тогтмол явуулах шаардлагатай гэж хэлж байгаа нь бидний ажлын үр дүн. Өнөөдөр дэлхий даяар цар тахлын хурцадмал байдал үүссэн, эдийн засаг амаргүй байгаа ч нийгмийн ач холбогдол талаас нь харж, ойлгож, дэмжиж байгаа нь чухал юм" гэв. Тэрээр үргэлжлүүлэн Батлан хамгаалах, Зэвсэгт хүчний шинэчлэлийн төлөө авч хэрэгжүүлэх ажил, арга хэмжээний талаар товч мэдээлэл өгсөн юм. Тухайлбал, "1990 оноос хойш Батлан хамгаалахын сайдаар 15 хүн томилогдон ажилласан байдаг. 16 дахь нь миний бие. Цэргийн хүн томилогдон ажилласан анхны тохиолдол нь хошууч генерал Ж.Гуррагчаа. Миний бие хоёр дахь нь. Батлан хамгаалах, Зэвсэгт хүчинд 35 дахь жилдээ алба хааж байгаагийн хувьд хийх ажил минь тодорхой. Алба хаагчдынхаа ажиллаж, амьдрах орчин нөхцөлийг нь сайжруулж, цэргийн алба хаасан иргэдийг нийгэмд давуу эрхтэй байх тогтолцоог бүрдүүлэх нэн тэргүүний зорилго тавиад ажиллаж байна. Цаашдаа 18 нас хүрсэн бүх эрчүүдээр хугацаат цэргийн алба хаалгаж, тэднээр дамжуулан нийгмээ зөв чиглүүлэх зорилготой. Төр, засгийн хэмжээнд ч бүрэн дэмжиж

байгаа. Миний анхны томлолт Зэвсэгт хүчний 336 дугаар ангиас эхэлж, үргэлжлүүлээд бүтээн байгуулалтад оролцож байгаа цэрэг, дайчдаа эргэсэн. Бүтээн байгуулалтад оролцож буй манай бие бүрэлдэхүүн шинэ түүх бүтээж байгааг хараад өөрийн эрхгүй бахархлаа.

Монгол Улсын Батлан хамгаалах бодлого, хууль тогтоомж өнгөрсөн хугацаанд тэр дундаа 2014 оноос өнөөдрийг хүртэлх хугацаанд амжилттай шинэчлэгдсэн. Нийгмийн чиг хандлага, бусад хуулиудтай нийцүүлж боловсронгуй болгосныг та бүхэн мэднэ. Эдгээр хуулиа хэрэгжүүлэх том ажил та бидний өмнө байна. ЗХЖШ-ын дарга, хошууч генерал Д.Ганзориг Зэвсэгт хүчний шинэчлэлийн асуудлаар томоохон ажлыг эхлүүлсэн нь маш зөв. Зэвсэгт хүчний нэгтгэл, ангиудын сургалт бэлтгэл, бэлэн байдлын тогтолцоо, дайчилгаа гээд бүх талыг нь цэргийн мэргэжлийн чиг хандлагатай, чадварлаг Зэвсэгт хүчинтэй байх суурийг тавьж эхэлсэнд нь баяртай байна. Энэ их зөв чиглэл. Үүний нэг илрэл нь Хуурай замын цэрэг болон Агаарын цэрэг гэсэн хоёр командлал бүрэн бие дааж үйл ажиллагаагаа явуулж эхлээд байна. Удирдлага, төлөвлөлт, менежментээ өөрсдөө аваад явчихдаг болчихлоо. Энэ мэтчилэн эрх зүйн шинэчлэл үр өгөөжөө өгч байна" гэлээ. Уулзалтын төгсгөлд Батлан хамгаалахын сайдын тушаалаар зарим офицер, ахлагч, ажилтан албан хаагчийг шагнаж тус ангийн захирагч, хурандаа Д.Жигжидсүрэнд Дайчилгаатай команд штабын хээрийн сургуулийг амжилттай зохион байгуулалцсанд нь "Талархан" гардуулсан юм.

Мөн Зэвсэгт хүчний Жанжин штабын дарга, хошууч генерал Д.Ганзориг Дайчилгаатай команд штабын хээрийн сургуульд идэвх зүтгэл гаргаж ажилласан алба хаагчдад талархал дэвшүүлж, цаашдын албанд нь өндөр амжилт хүслээ.

## ҮНДЭСНИЙ БИЧГИЙГ ТҮГЭЭН ДЭЛГЭРҮҮЛЭХ СУРГАЛТ ХОЁР ДАХЬ ЖИЛДЭЭ ...

(Түрүүч нь I нүүрт)

**Үндэсний батлан хамгаалахын их сургуулийн Нийгмийн ухааны тэнхимийн багш доктор, профессор Ц.НАРАНГЭРЭЛ:** -Би түүхийн багш мэргэжилтэй учраас судалгаа хийхэд үндэсний бичигт дадах зайлшгүй шаардлага бий болсон. Монгол бичгээр уншиж, хөрвүүлэхээс цаашгүй байсан миний хувьд тус сургалтад хамрагдан түвшингээ нэмэгдүүлж чадлаа. Компьютероор шивж, хэвлэж сурснаар хөдөлмөрийг хөнгөвчилж, түргэн шуурхай ажиллах боломжтойг ойлгон 45 хоногийн хугацаанд цагаа үр бүтээлтэй өнгөрүүлсэндээ баяртай байна. Багш хүний хамгийн гол үүрэг бол бусдад зааж сургах. Тиймдээ ч чадвараа сайжруулж оюутан, залуустаа анхан шатны мэдлэгийг нь түгээнэ. Монгол хэл, өв соёлоо хадгалж үлдэхийн тулд монгол бичгийг сурах хэрэгтэй, та бүхэн хичээгээд заавал сураарай.

**Цэргийн хөгжмийн коллежийн мэргэжлийн боловсролын тэнхимийн ахлах багш Г.БАТДОРЖ:** -Анх 4 дүгээр ангийн сурагч байхдаа сургуулийнхаа цэвэр бичгийн аварга болсноор монгол бичигт улам дурлан суралцаар ирсэн. Агуу их яруу найрагч Б.Ринчен гуай "Монгол хэл" шүлэгтээ эх хэл бол бидний хамгийн эрхэм нандин зүйл хэмээн магтсан байдаг. Монгол бичгийг өдөр тутмын хэрэглээ болгохгүй бол мартагдах аюулд хүрч байна. Тиймдээ ч үндэсний бичгийг түгээн дэлгэрүүлж, энэхүү сургалтад хамрагдсандаа баяртай байна.

# МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД ДАЙЧИЛГААТАЙ КОМАНД ШТАБЫН ХЭЭРИЙН СУРГУУЛИЙГ ӨНДРӨӨР ҮНЭЛЭВ



(Түрүүч нь I нүүрт)

Хээрийн сургуулийн явц, дүнтэй Монгол Улсын Ерөнхий сайд У.Хүрэлсүх, УИХ-ын гишүүн Д.Батлут, Засгийн газрын гишүүн, Батлан хамгаалахын сайд

хувь хүмүүст талархаж байгаагаа илэрхийлэхэд таатай байна” гэж онцлон хэлсэн.

Эх орондоо өргөсөн эр цэргийн тангарагтаа үнэнч байж, хуулиар хүлээсэн үүргээ биелүүлэн энэ удаагийн дайчилгаатай команд штабын хээрийн сургуульд оролцсон Орхон аймгийн цэргийн бэлтгэл үүрэгтнүүдийн идэвх чармайлт, хичээл зүтгэлийг хүрэлцэн ирсэн хүндэт зочид өндрөөр үнэлж буйгаа энэ үеэр мөн онцолж байсан юм.

Ингээд дайчилгаатай команд штабын хээрийн сургуульд оролцсон зарим бэлтгэл үүрэгтнүүдийн сэтгэгдлээс уншигч танд хүргэе.

гаруй хүнийг дайчилгаагаар татсан. Зарим ажилтнууд маань тус сургуульд оролцоогүй байна, чөлөө авмаар байна гэж хэлсэн ч би захирлын хувьд зөвшөөрөөгүй. Зарласан цагт нь оч, цугла гэсэн газар нь бэлэн бай гэж ажилтнууддаа үүрэг үүрэг өгсөн. Тэд маань ч бүрэн оролцлоо. Энэ сургуулиар бэлтгэл үүрэгтнүүд бид их зүйлийг сурсан. Миний хувьд 26 жилийн өмнө цэргийн албанаас гарсан ч эргээд тус сургалтаар хуучнаа сэргээж, залуу насаа дурсаад сайхан байлаа. Мөн сургуулийн сүүлийн өдөр навочдик операторчноор ажиллаж, буудлага хийсэн. Мэдээж, эхэндээ төсөөрсөн, мартсан зүйлс байсан ч хэдхэн хоног дадлага хийхэд зүгшрээд өөрт оногдсон үүргээ ямар ч асуудалгүй гүйцэтгэлээ. Эх орон дуудсан цагт үүргээ мадаггүй гүйцэтгэж чадна гэсэн үнэлэлтийг өөртөө өглөө.

**МАНАЙ ЦЕХЭЭС ГУРВАН ХҮН  
ТУС СУРГУУЛЬД ХАМРАГДСАН  
Бэлтгэл үүрэгтэн С.МЭНД-АМАР:**



**БЭЛТГЭЛ ҮҮРЭГТНҮҮД  
МААНЬ БҮХ ЗЭВСГЭЭР  
БУУДСАН, БАЙГАА  
ОНОСОН**

**Бэлтгэл дэд  
хурандаа Д.БАТСАЙХАН:**

-Би 1984 онд ЦНДС-д элсэн суралцаж, артиллерийн мэргэжил эзэмшсэн бөгөөд 1991 он хүртэл Зэвсэгт хүчний 123 дугаар ангид алба хаагаад 1991-1994 онд Зэвсэгт хүчний 120 дугаар ангид ажилласан. Дараа нь 1994-2016 он хүртэл Зэвсэгт хүчний 186 дугаар ангид алба хаасан. Ингээд 2016 онд цэргийн тэтгэвэрт гарснаас хойш яг гурван жил найман сар, долоо хоногийн дараа буцаад цэргийн жагсаалдаа нэгдлээ. Үнэхээр сайхан байна. Би арван жил батальоны захирагч хийсэн. Тус дайчилгаатай хээрийн сургуулиар мөн батальоны захирагчийн албан тушаалд томилогдон ажиллалаа. Орхон аймагт өмнө нь 2001 онд дайчилгаатай команд штабын сургууль болж байсан. Түүнээс хойш даруй 19 жил өнгөрчээ. Миний хувьд хийж сурсан ажлаа эргэн сэргээхэд урамтай байна. Ер нь нэгдүгээр зэргийн бэлтгэл үүрэгтнүүдийг долоо хоногийн дотор сурган д а д л а г а ж у у л ж , байлдааны буудлага хийлгэж байсан тохиолдол өмнө нь байгаагүй биз. Болдог гэдгийг дарга нар ирж харлаа. Бэлтгэл үүрэгтнүүд маань бүх зэвсгээр буудсан, байгаа оносон. Мөн цэргийн алба хаасан хүмүүст жагсаалын бэлтгэл хичээлийг заагаад ч хэрэггүй юм байна гэдгийг анзаарлаа. Ганц өдөр болоход л бүгд жигдрээд бэлтгэл сургуулилтаа хамрагдаад эхэлсэн. Цэргийн алба хаасан залуус маань шаардлагатай үед байлдааны үүрэг гүйцэтгэх бүрэн боломжтой гэдгээ энэхүү сургуулиар харууллаа.



**ЭХ ОРНОО ДУУДСАН ЦАГТ ҮҮРГЭЭ  
МАДАГҮЙ ГҮЙЦЭТГЭЖ ЧАДНА  
Бэлтгэл ахлах дэслэгч Ш.ДАВАНЯМ:**



-ЦНДС-ийг 1990 онд явган цэргийн байлдааны машины инженер мэргэжлээр төгссөн. 1993 он хүртэл Зэвсэгт хүчний 167 дугаар ангид салааны захирагчаар ажиллаж байгаад 1994 онд Зэвсэгт хүчний 186 дугаар ангид ротын захирагчаар томилогдоод жил гаруй хугацаанд ажилласны дараа “Эрдэнэт” ТӨҮГ-т ажилтнаар орсон. Түүнээс хойш тус үйлдвэрт 20 гаруй жил ажиллаад хувийн бизнест хөл тавьснаар, “Эрдэнэт механик сервис” компанийг үүсгэн байгуулаад ажиллаж байна. Манай компани нь 80 гаруй ажилтантай бөгөөд хүнд машин механизмын засвар үйлчилгээ, уул уурхайн олборлолт эрхэлдэг аж ахуйн нэгж юм. Би өөрөө тус дайчилгаатай хээрийн сургуульд оролцохоос гадна ажилчдаа мөн хамруулсан. Компаниас үндсэндээ 10



-2014 оны хоёрдугаар ээлжээр цэрэгт татагдаж, Зэвсэгт хүчний 336 дугаар ангид цэргийн алба хаасан. Одоо “Эрдэнэт” ТӨҮГ-ийн ил уурхайн цехэд хүнд даацын дугуйт ачигчийн машинистаар ажиллаж байна. Хэдий ажилтай байсан ч иргэний цэргийн үүргээ биелүүлэн цэргийн алба хаасан цагаа дурсаж, жагсаалд нэгдэж, хийморио сэргээсэндээ туйлын баяртай байна. Эх орноо хамгаалах эр цэргүүдээрээ бахархаж байна. Дайчилгаатай сургуульд татагдах өдрийн өмнө би үйлдвэрт ээлжтэй байсан юм. Тэгээд өглөө нь ажлаасаа буугаад гэртээ ч харилгүй шууд хээр гарсан. Явлаа ч гэж хэлэлгүй хээр гарсныг минь мэдээд эхнэр маань үнэхээр гайхсан гэсэн. Надтай хамт манай цехээс гурван хүн тус сургуульд хамрагдсан бөгөөд бүгд сэтгэл хангалуун байгаа. Болзошгүй тохиолдолд дан ганц Зэвсэгт хүчний алба хаагчид бус бэлтгэл үүрэгтнүүд ч мөн эх орноо хамгаалж, газар шороонхоо төлөө тэмцэх ёстой гэж боддог. Үүнийгээ ч өнөөдөр харуулж чадсан байх гэж бодож байна.

**ЭХ ОРНОО ХАМГААЛАХ ҮЙЛСЭД ХЭЗЭЭД БЭЛЭН  
Бэлтгэл үүрэгтэн С.ҮНЭНБАТ:**



-Би 2005 онд Дорнод аймаг дахь Хилийн цэргийн 0306 дугаар ангид хугацаат цэргийн албаа хаасан. Дараа нь Зэвсэгт хүчний 326, 186 дугаар ангид цэргийн гэрээт албанд ажилласан. Түүнээс хойш барилгын салбарт ажиллаж байна. Монголын түүх бол цэргийн түүх байдаг. Монголчууд бид дэлхийд төрт ёсыг үүсгэн байгуулсан цагаас эхлэн эх орныхоо тусгаар тогтнол, бүрэн эрхт байдал, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдлын төлөө баатарлагаар тэмцэж ирсэн цэрэг, Зэвсэгт хүчний баялаг түүхтэй ард түмэн юм. Миний хувьд дайчилгаатай хээрийн сургуулиар иргэний цэргийн үүргээ биелүүлсэндээ баяртай байна. Явган цэргийн байлдааны машины даргаар ажилладаг байсан учир энд ирээд эзэмшсэн мэргэжлээрээ үүрэг гүйцэтгэлээ. Мэдээж эхэндээ мартсан зүйлс байсан боловч хэдхэн цаг дадлага хийгээд мэргэжлийнхээ чадварыг сэргээчихлээ. Ямар ч байсан ЯЦБМ-даа суугаад хийморио сэргээгээд авлаа. Сэтгэгдэл маш өндөр байна. Хугацаат болон цэргийн гэрээт алба хааснаас хойш хээр гарч, цэргийн жагсаалд нэгдээгүй байсан миний хувьд залуу насны минь дурсамж сэргээд сайхан байна. Орхон аймгийн бэлтгэл үүрэгтнүүд хэзээд энэхүү орноо хамгаалах үйлсэд бэлэн гэдгээ энэ сургуулиар харуулж чадлаа.

**Ахлах дэслэгч М.МӨНХЗОРИГ**

Г.Сайханбаяр, Зэвсэгт хүчний Жанжин штабын дарга, хошууч генерал Д.Ганзориг, Зэвсэгт хүчний Хуурай замын цэргийн командлагч, бригадын генерал Б.Амгаланбаатар тэргүүтэй албаныхан болон аймаг, орон нутгийн удирдлагууд танилцаж, сургуульд амжилттай оролцсон бие бүрэлдэхүүнийг шагнаж, цэргийн цол олголоо.

Энэ үеэр Монгол Улсын Ерөнхий сайд У.Хүрэлсүх “Та бүхэн мэдэж байгаа, УИХ-ын ээлжит бус чуулганаар 2020 оны улсын төсөвт тодотгол хийхээр хэлэлцэж байгаа хэдий ч энэ удаагийн дайчилгаатай сургуулийг Монгол Улсын Засгийн газрын тогтоолоор төлөвлөгөөний дагуу явуулсан нь уг сургуулийг зайлшгүй явуулах хэрэгцээ, шаардлага байгааг нотлон харуулсан явдал юм. Орчин цагийн Зэвсэгт хүчин үүсэж хөгжсөний 100 жилийн ойн босгон дээр дайчилгаатай сургуулийг амжилттай зохион байгууллаа. Дайчилгааны даалгаварт заагдсан бэлтгэл нөөцийн бие бүрэлдэхүүн, техникийг тогтоосон хугацаанд нийлүүлж, хуулиар хүлээсэн үүргээ биелүүлсэн байгууллага, аж ахуйн нэгжийн удирдлага, хамт олон болон цэргийн бэлтгэл үүрэгтэн та бүхэнд талархаж байгаагаа илэрхийлье. Дайчилгаатай команд штабын хээрийн сургуулийг төрийн захиргааны удирдлагаар хангаж ажилласан Батлан хамгаалах яам, мэргэжлийн удирдлагаар хангаж, удирдан явуулсан Зэвсэгт хүчний Жанжин штаб болон сургуульд амжилттай оролцсон Зэвсэгт хүчний 186 дугаар анги, Орхон аймгийн ЗДТГ, Цэргийн штабын бүрэлдэхүүн, бэлтгэл үүрэгтнүүдэд албаны өндөр амжилт хүсье” гэв.

Засгийн газрын гишүүн, Батлан хамгаалахын сайд Г.Сайханбаяр “Энэхүү сургуулиар эх орныхоо тусгаар тогтнол, бүрэн эрхт байдлыг хэрэгцээтэй цагт сахин хамгаалах цэргийн бэлтгэл үүрэгтнүүдээ тодотгож, сурган дадлагуулж, жигдрүүлээд зогсохгүй зэвсэг, техникийг эзэмших ур чадварыг нь нэмэгдүүлээ. Тус сургуульд оролцсон цэргийн бэлтгэл үүрэгтнүүдээр дамжуулан дан ганц Орхон аймаг бус бусад аймаг, нийслэлийн иргэд, хүүхэд, залуусыг цэрэг-эх оронч үзэл, хүмүүжлээр сурган хүмүүжүүлэхэд чухал ач холбогдолтой юм. Улсын Их Хурал, Засгийн газраас Батлан хамгаалах салбарын эрх зүйн орчныг боловсронгуй болгох, Зэвсэгт хүчнийг хөгжүүлэх асуудалд анхаарал хандуулан ажиллаж байгаа. Орон нутгийн хамгаалалтад тулгуурласан батлан хамгаалах нэгдмэл тогтолцоо, мэргэжлийн цэрэгт суурилсан Зэвсэгт хүчнийг бэхжүүлэх, орон нутгийн цэрэг, орон нутгийн томилгоот нэгжийн үйл ажиллагааг жигдрүүлэхэд төрийн захиргааны төв болон нутгийн захиргааны байгууллага, аймаг, нийслэлийн бүх шатны Засаг дарга, Иргэдийн төлөөлөгчдийн хурлаас анхаарал хандуулж ажиллах нь чухал байна гэдгийг онцлон тэмдэглэе. Сургуулийг зохион байгуулахад оролцсон бүх аж ахуйн нэгж байгууллагуудын удирдлага, ажилтан албан хаагчдад талархсанаа илэрхийлье” гэсэн юм.

Зэвсэгт хүчний Жанжин штабын Бодлого, стратегийн төлөвлөлтийн газрын дарга, хурандаа Ч.Цогтжаргал “Монгол Улс өргөн уудам нутагтай, цөөн хүн амтай учир эх орноо болзошгүй аюул заналаас бүх нийтийн оролцоотойгоор хамгаалах учиртай. Тиймээс Зэвсэгт хүчний бэлэн байдалтай дайчилгааны бэлэн байдал салшгүй холбоотой бөгөөд үүнд бэлтгэл үүрэгтнүүдийн үүрэг, оролцоо чухал. Иймд дайчилгааны бэлтгэл нөөцийг бүрдүүлэх, тэднийг сурган дадлагуулах зорилгоор энэ удаагийн дайчилгаатай стратегийн команд штабын сургуулийг зохион байгууллаа. Бэлтгэл үүрэгтнүүд маань маш сайн оролцсон. Зарим нь сайн дураараа оролцье гэж ирсэн. Ингэснээр манай ард түмэн эх орноо хамгаалах үйлсэд хэзээд бэлэн гэдгээ нэг талаар харуулсан гэж бодож байна. Сургуулийг зохион байгуулахад туслалцаа үзүүлсэн Орхон аймгийн удирдлага, аж ахуйн нэгжүүд,

# ТЭНГЭР НЬ ЦЭЛМЭГ ГАЗАРДАЛТ НЬ ЗӨӨЛӨН БАЙЛАА

"Тайван цагт хөлс их гаргавал дайны цагт цус бага урсана" гэсэн үг хүн төрөлхтний олон жилийн зэвсэгт тэмцлийн сургаж, туршлагаар батлагдсан эгэл үнэн юм. Зэвсэгт хүчний 084 дүгээр ангийн сургалт бэлтгэл ч энэхүү үзэл санаан дор явагдаж, дэлхийн тусгай хүчний анги, салбаруудын ур чадвар, үлгэр дуурайллаас харилцан суралцаж, бэлтгэлжилтээ улам бүр сайжруулсаар иржээ. Тус ангийн бүрэлдэхүүн ОХУ, АНУ, Өмнөд Солонгос, Бельги, Турк зэрэг улс орнуудын тусгай хүчнүүдтэй хамтарсан бэлтгэл, сургуулилт хийж байсан арвин туршлагатай хамт олон. Ард түмний дунд "Шүхэрт десантын" хэмээн алдаршсан тус анги өнгөрсөн 50 гаруй жилийн хугацаанд цэргийн алба хаагчдыг анх удаа шүхрээр буулгаж, "Онц анги"-ийн алдар хүртэж, олон удаагийн тэргүүн, сайн ангийн болзол ханган Зэвсэгт хүчинд анхны тусгай хүчний шавыг тавьсан бахархам түүхтэй анги юм. Түүнчлэн шүхрийн тусгай үүргийн шөнийн, модны, бүлгийн, усны, хэт өндрийн болон нам өндрийн буултуудыг амжилттай зохион байгуулсаар ирсэн. Мөн Батлан хамгаалах бодлого, зорилт, Зэвсэгт хүчний үйл ажиллагааг сурталчлах, иргэн-цэргийн харилцааг бэхжүүлэхэд хувь нэмрээ оруулсаар иржээ. Тэд өнгөрсөн хугацаанд Булган, Архангай, Өвөрхангай, Баянхонгор, Орхон, Дархан-Уул, Хөвсгөл, Дундговь, Дорнод, Говь-Алтай, Завхан аймгуудад шүхрийн үзүүлэх буулт болон дадлага сургуулилтыг хийж байсан юм.

Энэ удаад тус анги 2020-2021 оны сургуулийн жилийн сургалт бэлтгэлийн төлөвлөгөөний дагуу 8 дугаар сарын 17-21-ний өдөр Архангай аймгийн Өгий сумын Өгий нуурын нутаг дэвсгэрт нам өндрийн, өдрийн болон шөнийн, усны мандал дээр шүхрийн буултын дадлага, сургуулилтыг амжилттай зохион байгуулсан юм. Шүхрийн дадлага буултаар шүхэрчдийн ур чадварыг нэмэгдүүлж, багийн ажиллагааг сайжруулсны зэрэгцээ Өгий нуурын ойр орчмын хог хаягдлыг цэвэрлэж, нийгмийн харуцлагын хүрээнд байгаль экологид ээлтэй орчныг бүрдүүлжээ. Мөн энэ далимд орон нутгийн иргэд болон аялагчдад зориулан ЦДБЭЧ-ын цөөнгүй уран бүтээлчид урлагийн тоглолтоо толилуулж, иргэн-цэргийн харилцааг бэхжүүлэх үүргээ хамт гүйцэтгэсэн юм.

Өмнө нь ангийн байрлалд бие бүрэлдэхүүн бие бялдрын бэлтгэл, гараа, газардалтын бэлтгэл, шүхрийн эвхэлтийн дадлага зэрэг сургалтуудыг тодорхой хугацаатай хийж гүйцэтгэсэн нь энэхүү сургуулийн үндэс суурь болжээ.

Сургуулийн төгсгөлд ангийн захирагч, хурандаа Б.Хаш-Эрдэнэ "2020 оны сургуулийн жилийн сургалт бэлтгэлийн төлөвлөгөөний дагуу тусгай үүргийн шүхрийн буултуудаа Зэвсэгт хүчний 303 дугаар ангийн дэмжлэгтэйгээр амжилттай явуулж дууслаа. Ангийн бие бүрэлдэхүүн усны мандал дээрх, өдөр, шөнийн, хэт өндрийн болон нам өндрийн, бүлгийн гэсэн сургалт, дадлагад хамрагдсанаар Монгол Улсын өнцөг булан бүрд байгаль, цаг уурын ямар ч нөхцөлд үүрэг гүйцэтгэх боломжтой болж байгаагаараа онцлог юм. Мөн Зэвсэгт хүчний 311 дүгээр ангийн тодорхой тооны алба хаагчдыг дадлага буултдаа хамрууллаа" гээд бие бүрэлдэхүүнийхээ цаашдын албанд нь өндөр амжилт хүслээ.

Шүхрийн буултад оролцсон алба хаагчид ийн ярьж байна.

## НУУРЫН ОЙР ОРЧМЫН ТАЛБАЙГ ЦЭВЭРЛЭЖ ЗӨВ ҮЛГЭР ДУУРАЙЛ ҮЗҮҮЛЛЭЭ Ахмад Ч.НЯМСҮРЭН:



"Ангийн тусгай үүргийн шүхрийн буулт амжилттай зохион байгуулагдсанд баяртай байна. Ангийн удирдлага, хамт олон, шүхэрчин алба хаагчид шүхрийн дадлага буултаа хийхээс гадна Батлан хамгаалах бодлого, зорилт, Зэвсэгт хүчний үйл ажиллагааг сурталчлах, иргэн-цэргийн харилцааг бэхжүүлэх, ангийн үйл ажиллагааны онцлогийн талаар иргэд, хүүхэд, залууст таниулахын зэрэгцээ тэдэнд эх оронч үзэл төлөвшүүлэхэд чиглэсэн ажлуудыг хийлээ. Өгий нуурыг зорьж аялж, амарч байгаа иргэд, үйлчилгээ эрхэлж байгаа аж ахуйн нэгжүүдэд хандаж ил задгай хог, хаягдал хаяхгүй байх, нуурын усыг бохирдуулахгүй байх талаар уриалсан зурагт самбарыг эргийн хажууд байршуулж, тус нуурын ойр орчмын талбайг цэвэрлэн зөв үлгэр дуурайл үзүүлээ. Мөн урлагийн хэсэгчилсэн тоглолтыг зохион байгуулсанд нутгийн иргэд болон аялж, амарч буй хүмүүс сэтгэгдэл өндөр байгаагаа бидэнд илэрхийлсэн."

## ОДООГООР 62 УДААГИЙН ШҮХРИЙН БУУЛТ ХИЙГЭЭД БАЙНА

Ахлах дэслэгч А.МӨНХТУЛГА:



"Би дунд сургуулиа төгсөхөөсөө өмнө ямар мэргэжил сонговол надад илүү тохирох бол гэж өөрөөсөө асууж, дүгнэлт хийсэн. Мөн аав минь надад өөрийнхөө гаргасан шийдвэрээс няцахгүй, аливаа зүйлд тууштай байвал амжилтад хүрдэг хэмээн сургаж билээ. Ингээд хүсэл мөрөөдлийнхөө дагуу цэргийн хүн болохоор шийдэж шалгалтаа амжилттай өгч хүссэн хувиараа авч чадсан. 2012-2017 онд БНСУ-ын Хуурай замын явган цэргийн академийг төгсөж 50 гаруй жилийн түүхтэй Зэвсэгт хүчний 084 дүгээр ангидаа томилогдсондоо маш их баярлаж бас эмээж байсан. Яагаад гэвэл би Монгол Улсын элит дайчдын дунд алба хааж чадах болов уу гэсэн эргэлзээ төрсөн хэрэг л дээ. Ангийнхаа ах нар болон зааварлагч багш, офицер, ахлагч нараас суралцаж, мөн бусад оронтой хамтарсан тусгай хүчний хээрийн сургуулиудаар их зүйлийг сурсаар байна. Цаг

хугацаа өнгөрөх тусам өөртөө итгэх итгэл нэмэгдэж, тус ангид алба хааж буй хамт олноороо бахархах болсон. Анх БНСУ-ын академид сурч байхдаа 2014 онд шүхрээр бууж үзсэн. Нуулгүй хэлэхэд, онгоцонд суугаад нисэж байхдаа эхлээд айдастай байсан ч хэрвээ би шүхрээр бууж чадахгүй бол хүний нутагт Мөнхтулга айсан гэж ярихгүй. Монгол гэдэг эх орны минь нэр гарах учраас онгоцны хаалгаар шийдэмгий гарч үсэрч байсан. Энэ сургалтын буулттай нийлээд би 62 удаагийн шүхрийн буулт хийгээд байна.

## ӨМНӨХӨӨСӨӨ ИЛҮҮ ИХ ЗҮЙЛ СУРЛАА

Ахлах дэслэгч  
М.ДОЛГОРСҮРЭН:



"Би хүсэл мөрөөдлөө дагаж энэ албанд орж, тууштай ажиллаж байгаа залуусын нэг. Мэдээж албандаа ажиллах хугацаанд саад бэрхшээл, мэдэхгүй чадахгүй зүйл олон гарч байсан ч өөрийн итгэл үнэмшил, хамтран ажиллаж байгаа сайн удирдлага, хамт олон болон гэр бүлийнхээ хүчинд тэр бүхний ард гарч чадсан. Аливаа зүйл хоёр талтай байдаг учраас тохиолдсон саад бэрхшээлийг нөгөө өнцгөөс нь харж нүүр тулж, өөрийгөө бусдад харуулах, таниулах хэрэгтэй гэж би боддог. Ангидаа томилогдож ирээд олон найз нөхөдтэй болж тэднээсээ заавар, зөвлөгөө авч их зүйлийг сурсаар байна. Анх нисдэг тэргэнд суугаад газар орныг дээрээс харах үнэхээр сайхан санагдаж байсан. Би мөр зэрэгцэн алба хааж буй залуустаа эмэгтэй хүн шүхрээр айдасгүй үсэрч буугаад байхад би яагаад эмээх ёстой юм гэсэн бодол төрүүлэхийн тулд шийдэмгий зоригтой байдаг. Нийт 64 удаа шүхрийн буулт хийсэн. Энэ дадлага сургалтаар дөрвөлжин бункертэй шүхрээр 10 удаа буулт хийснээс хоёр нь бага зэрэг хатуу байсан. Хүн алдаанаасаа суралцдаг гэдэг шиг өмнөхөөсөө илүү их зүйлийг суралцахыг хичээж байна. Зэвсэгт хүчний бүх эмэгтэй алба хаагчид маань айдасгүйгээр нүүр тулж бусдадаа үлгэр дуурайл болж яваарай гэж хэллээ."

## АНХ УДАА ШӨНИЙН БУУЛТ ХИЙЛЭЭ

Ахлах дэслэгч  
Л.ЭРДЭНЭБИЛЭГ:



"ҮБХИС-ийг 2015 онд Ерөнхий цэргийн командын офицер мэргэжлээр төгсөж Зэвсэгт хүчний 186 дугаар ангид салааны захирагчаар ажиллаж байгаад 2019 онд Зэвсэгт хүчний 084 дүгээр ангид томилогдсон. Өнгөрсөн өвөл анх шүхрээр



бууж үзсэн. Энэхүү шүхрийн буултаар анх удаа шөнийн буулт хийж үзлээ. Мөр зэрэгцэн алба хааж буй залуусаасаа болон зааварлагч багш нараас их зүйл сурч, дадлагажиж байна. Ангийнхаа бие бүрэлдэхүүнд тэнгэр нь цэлмэг газардалт нь зөөлөн байг гэж ерөөе.

## АНХ БУУХДАА ЯМАР Ч АЙДАСГҮЙ ҮСЭРСЭН

Ахлагч Г.БАЯРМАА:



"Би эмэгтэй гээд чадахгүй, мэдэхгүй гэж хойш сууж аливаа зүйлийн ард үлдээд байхыг хүсдэггүй. Цэргийн мэргэжлийг тэр тусмаа тусгай томилолын батальонд алба хаахыг маш их хүсэж байж сонгосон болохоор хойш суулгүйгээр бусадтайгаа адилхан хөдөлмөрлөхийг хичээдэг. Шүхрээр анх буухдаа ямар ч айдасгүй зоригтой үсэрч байсан ч дараагийн буултаар бага зэрэг айсан, гэхдээ шүхэр задрахад агаарт дүүлэн нисэх мэт сайхан мэдрэмжийг авдаг."

## 100 ДАХЬ УДААГИЙН ШҮХРИЙН БУУЛТАА ХИЙСЭН

Ахлагч Б.ПҮРЭВБААТАР:  
"Би 2013 онд ҮБХИС-ийн харьяа Мэргэжлийн ахлагч бэлтгэх төвийг төгсөөд Зэвсэгт



хүчний 084 дүгээр ангид томилогдон ирж байлаа. Бага байхаасаа л цэрэг, цагдаагийн холбогдолтой кино үзэж, түүнийгээ дагаад цэргийн хүн болох мөрөөдөлтэй байсан. Мөрөөдлөө биелүүлж "шүхэрт десантын" тодотголтой ангид дадлага хийж байсан. Анх удаа буух үед хоосон орон зай руу үсрэхэд мэдээж багагүй айдастай, төсөөлөгдөхгүй байсан. Туршлагатай ах нараасаа их зүйлийг сурч мэдэж 50 гаруй жилийн түүхтэй ангийнхаа цаашдын зам мөрийг хамт бичилцэж яваадаа сэтгэл хангалуун байдаг. Энэ удаагийн шүхрийн буултын сургалт дадлагаар 100 дахь удаагийн шүхрийн буултаа хийсэндээ баяртай байна.

## БУУЖ ЯВАХДАА ХАШХИРЧ ҮЗСЭН

Ахлагч Э.БОЛД-ЭРДЭНЭ:



"2014 онд сургуулиа төгсөж очоод ангийнхаа зааварлагч багш нарын сургалтад хамрагдсанаар дараа жил нь Зэвсэгт хүчний 337 дугаар ангид очиж шүхрээр бууж байсан. Анх шүхрээр буухдаа онгоцны хаалгаар үсрэх тэр агшинд дотроос хамаг юм аваад шидчих шиг л болсон юм. Тэгээд агаарт бууж явахдаа баярлаад хаширч үзсэн. Энэхүү сургалт дадлагаар өөрийнхөө ур чадварыг нэг шат ахиуллаа. Энэ удаад дөрвөлжин бункертэй шүхрээр бууж туршлага хуримтлуулаад байна. Өнгөрсөн хугацаанд нийт 68 удаа шүхрээр буусан."

Ахлах ахлагч Г.БАТ-ЭРДЭНЭ

ЗЭВСЭГТ ХҮЧИН-100 ЖИЛ

# УСЧИН ДАЙЧДЫН НЭГ ӨДӨР

Булган аймгийн Хангал сумын Хялганат тосгоныхон баруун талаараа Хантайн нуруу, хойт талаараа Бүтээлийн нуруу, зүүн талд Бүрэнгийн нуруугаар хүрээлэгдэж, Сэлэнгэ

юм.

Эхлээд цэргийн байраар орлоо. Сувилагч бүсгүй энэ өдөр харуул, хоногийн манаанд гарах бүрэлдэхүүнийхээ даралтыг үзэж, заавар, зөвлөмж өгч байв. Их



мөрний сав газрыг эзэгнэнхэн төвхнөжээ. Эл тосгоныхон Хантайн нурууны ойн фондод түшиглэн байгуулагдаж, өнөөгийн Хөтөл, Дархан, Эрдэнэт хотын бүтээн байгуулалтад оролцож, мод, модон бүтээгдэхүүнээр хангасан гавьяатай ард түмэн юм байна. Булган аймгийн Хангал сумын дөрөвдүгээр багаар овоглогдог атлаа сумын төвөөсөө ч том, хүн амынхаа тоогоор ч хавь илүү санж. Байгалийн үзэсгэлэн төгөлдөр ийм л газарт Зэвсэгт хүчний 234 дүгээр ангийнхан үйл ажиллагаагаа явуулж байна. Зэвсэгт хүчиндээ төдийгүй Монгол Улсдаа цор ганц Гүүр, ус гатлалтын тусгай батальон гэдгээрээ алдартай тус ангид Зэвсэгт хүчний Жанжин штабын дарга, хошууч генерал Д.Ганзориг, Зэвсэгт хүчний Хуурай замын цэргийн командлагч, бригадын генерал Б.Амгаланбаатар нар 8 дугаар сарын 22-ны өдөр ажиллалаа. Томилолтын эхэнд Зэвсэгт хүчний 234 дүгээр ангийн захирагч, дэд хурандаа Ц.Батхүү ангийн түүх, дайчин замнал, амжилт бүтээл, бэлэн байдлыг хангах хүрээнд явуулсан сургалт бэлтгэл, сургалтын материаллаг баазыг дээшлүүлэх чиглэлээр хэрэгжүүлсэн ажил, зэвсэглэл, цэргийн техникийн бэлэн байдал, төмөр замын бүтээн байгуулалт дахь оролцоо, алба хаагчдын нийгмийн хамгаалал зэрэг өргөн хүрээнд танилцуулга хийсэн юм. Тус ангийн 40 жилийн ой ирэх онд тохиох ажээ. Түүхт ойг угтаж, хэд хэдэн бүтээн байгуулалт өрнүүлсэн танилцуулж, алба хаагчдынхаа нийгмийн хамгааллыг дээшлүүлэх хүрээнд өөрсдийн нөөц бололцоогоо дайчлан албан тушаалын орон сууц болон спортын төвдөө бүрэн хэмжээний засвар, шинэчлэл хийж, шинээр зургаан айлын орон сууц барихаар төлөвлөж буйгаа ч дурдлаа. Үүний дараа Зэвсэгт хүчний Жанжин штабын дарга, хошууч генерал Д.Ганзориг, Зэвсэгт хүчний Хуурай замын цэргийн командлагч, бригадын генерал Б.Амгаланбаатар нар усчин дайчдын штабын болон цэргийн байр, соёлын төв, уурын зуух, цэргийн халуун ус, номын сан, агуулахууд, спорт төв, цэргийн гал тогоо, зэвсэглэл, цэргийн техникийн хадгалалт, хамгаалалт, арчилгаа зэрэгтэй танилцаж, тэдний гол ашиглагддаг инженерийн багаж хэрэгслүүдийг нь үзэж сонирхон, шинээр төхөөрөмжлөн тохижуулж байгаа Сургалтын төвөөр зочилсон

эмч нь БНӨСУ-д энхийг сахиулах ажиллагаанд үүрэг гүйцэтгэж байгаа учир арыг нь сувилагч Д.Цэцэгсүрэн дааж яваа нь энэ ажээ. Дархан-Уул аймаг дахь Анагаах ухааны их сургуулийг бага эмч мэргэжлээр төгссөн энэ бүсгүй оюутны ширээнээс гараад л тус ангид үүрэг гүйцэтгэж байгаа бөгөөд Хялганат тосгондоо ээж Д.Цэндхүүгийн хамт амьдардаг гэнэ. Цаашдаа цэргийн хүн болох мөрөөдөлтэй, хамт олон нь томилогдож ирснээс нь өнөөг хүртэл халуун сэтгэлээр дэмжин тусалдаг нь талархаж явдаг, ажил гүйцэтгэхэд дутагдаж гачигдах зүйлгүй гэлээ.

## ГЭРЭЭТ ЦЭРГҮҮД АХЛАГЧ БОЛОХ ХҮСЭЛТЭЙ

Албаныхан үргэлжлүүлээд "Инженерийн хотхон" буюу сургалтад ашиглагдаж буй



дэлгэгдсэн гүүр дээр очлоо. Ахлах дэслэгч Б.Маралхүү нарын алба хаагчид цэргийн гэрээт алба хаагчдаа гүүр дэлгэгдсэн үед хэрхэн үүрэг гүйцэтгэх талаар хичээл зааж байв. Хошууч генерал Д.Ганзориг гэрээт цэргүүдээс "Цэргийн албанд ямар байна вэ?" гэж асуухад бүгд "Бахархмаар байна" гэлээ. Тус ангийн захирагч, дэд хурандаа Ц.Батхүү "Орон нутагтаа цэргийн албыг сурталчилсан өдөрлөг, уулзалт, ярилцлагуудыг шат дараатай зохион байгуулдаг. Энэ үеэр орон нутгийн залуус цэргийн гэрээт албанд элсэх хүсэлтээ ихээр илэрхийлж байна. Манай залуусын олонх нь Булган, Орхон аймгийнх" хэмээн нэмж тодотгов.

Хугацаат цэргийн албыг хамтдаа хаасан залуус ч тэдний дунд байсан нь байлдагч Б.Батзаяа, С.Соёл-Эрдэнэ нар. Хоёул 2018 оны хоёрдугаар ээлжээр Зэвсэгт хүчний 013 дугаар ангид хугацаат цэргийн алба хаасан байна. Цэргийн алба хаагч болохоо хоорондоо ярилцаагүй,

санаандгүй тохиолдлоор дахин таарсан нь тэдний нөхөрлөлийг улам бататгаж чадсан гэнэ. Байлдагч Б.Батзаяагийн хувьд цэргийн алба хаагчдаас хамгийн залуу нь бөгөөд Орхон аймгийн Ерөнхий боловсролын 14 дүгээр дунд сургуулийг дүүргээд хугацаат цэргийн алба хаажээ. Халагдаж ирээд ердөө гуравхан сарын дараа тус ангид цэргийн гэрээт алба хаагчаар элсэж, гүүр дэлгэх, усан саад гатлах техник, гамшиг, ослын үед хүн, мал, техникийг авран хамгаалах, тусламж үзүүлэх арга ухаанаар суралцаж эхэлсэн аж. Цаашдаа ахлагч болон улирах мөрөөдөлтэй яваа гэнэ. Тэр бас цэргийн гэрээт алба хаагчийн ажиллаж амьдрах байнгын бүрэлдэхүүнээс дутахааргүй нөхцөл боломж нь сайжирсанд сэтгэл хангалуун буйгаа ч илэрхийлэв. Байлдагч Б.Батзаяа удахгүй ээлжийн амралтаа аваад эх орныхоо үзэсгэлэнт газруудаар аялах төлөвлөгөөтэй ажээ.

Харин байлдагч С.Соёл-Эрдэнэ Булган аймгийн Сэлэнгэ сумынх. Цэргийн алба түүнд эх орноо хайрлах сэтгэл, өөртөө итгэх итгэл, дайчин чанар, сурч мэдэж, дадлагажих их хүсэл тэмүүлээр цэнэглэж буйг хамгийн эхэнд онцлов. Аав Ё.Сонгууль, ээж Д.Буянбадрах нартаа хайртай шүү гээд "Эх орон, аав, ээж гурвыгаа яг адилхан хайрладаг" гэлээ. Тэрээр бусад нөхдийн адил ахлагч болон улирах хүсэлтэй.

Байлдагч О.Бямбацогт, Д.Бат-Эрдэнэ нар ч мөн ялгаагүй Монгол Улсдаа цор ганц Гүүр, ус гатлалтын тусгай батальонд үүрэг гүйцэтгэж байгаадаа баяртай байдаг. Усчин дайчдын нэгэн эд эс

нь болж байгаа минь их хувь заяа гэгцээв. Байлдагч О.Бямбацогт Булган аймгийн Баян-Агт сумынх бөгөөд спортоор хичээллэх дуртай. Цэргийн гэрээт алба хаагч байнгын бүрэлдэхүүн шиг ажлын найман цагаар ажиллаж, оройд гэртээ харьдаг, дотоод сургалт, дадлагууд болон энхийг дэмжих ажиллагаанд үүрэг гүйцэтгэх боломжтой гээд албаныхаа тухай магтана лээ. Тэдний гурван ч онжав өдгөө БНӨСУ-д үүрэг гүйцэтгэж байгаа ажээ.

Хамгийн холоос буюу Баян-Өлгий аймгийн Цэнгэл сумаас цэргийн гэрээт албанд ирсэн байлдагч Д.Бат-Эрдэнэ аав Дамдинсүрэн, ээж Халтархүү нартаа "Хүү нь сайн байгаа. Хүсэл мөрөөдлөөрөө яваа учир алзахгүй ээ" гэж дамжуулсан. "Манай Баагийнгийн аав нь аймгийн аварга малчин хүн байдаг гэсэн. Тэр багаасаа малын захад өссөн болохоор морь сургахдаа эрэмгий юм билээ. Бас их тусч, өрөвч, төлөв томоотой" гэж бусад нөхөд нь түүнийг магтаж байсан юм.



## ЭНГИЙН АЖИЛТНУУД ИЖИЛ ХУВЦСААР ЖИГДЭРЧЭЭ


Усчин дайчдын ялгарах бас нэг онцлог нь энгийн ажилтан албан хаагчид нь гүйцэтгэж буй ажил, үүргээсээ хамааран ижил төрлийн хувцсаар жигдэрсэн байх агаад энэ нь жагсаал дунд тун цэгцтэй харагдаж байв.



Уурын зуухныхан гэхэд ажлын хувцсаар жигдэрчихсэн ЗХЖШ-ын даргаа ажлын талбар дээрээ хүлээн зогсож байлаа. Уурын зуухны механикч Г.Лхагвасүрэн гуайн өгсөн мэдээллээр уурын зуух нь өвөлдөө ангийн районыг бүхэлд нь халаадаг ба нүүрсээ Өвөрхангай аймгийн Нарийнтээл сумын "Баян тээг" нүүрсний ордоос татдаг байна. Энэ хамт олон дөрвөн слесарь, 12 галчтай. Одоогоор зарим галч нь түлшний модоо бэлтгэхээр хөдөө явсан, уурын зуухандаа жил бүр их, бага засваруудыг тогтмол явуулдаг ч тэр ярилаа.

Тус ангид ажиллаад 25 жил болж байгаа түүнийг Хуурай замын цэргийн командлагч, бригадын генерал Б.Амгаланбаатар хамт олных нь өмнө индэр дээр дуудаад "Манай Лхагваа хамт олноо дулаахан өвөлжихөд нь олон жил идэвх санаачилгатай зүтгэж яваа ажилтан. Уурын зуухаа элэгдэл ихтэй байна гэхгүйгээр үр хүүхэд шигээ арчилж, тордож явдагт нь баярлалаа" хэмээн дурсгалын зүйл гардуулсан юм. Командлагчаас дурсгалын зүйл гардсан өөр нэг алба хаагч нь ажиллагааны ахлагч, ахлах ахлагч Д.Оргилсайхан. 2008 онд Мэргэжлийн ахлагч бэлтгэх төвд суралцаж төгсөөд Зэвсэгт хүчний 330 дугаар ангиас ажлын гараагаа эхэлсэн байна. Энхийг сахиулах ажиллагаанд хоёр удаа үүрэг гүйцэтгэсэн туршлагатай, хань, охины хамт амьдардаг бөгөөд энэ жил албан тушаалын "Ахлагч" хотхоныг засварлахад ихээхэн үүрэгтэй оролцжээ.

Мөн усчин дайчдын ус гатлах, шумбахад болон тэсэрч дэлбэрэх бодис, саад арилгахад хэрэглэгддэг инженерийн багаж



хэрэгслүүд, хийлдэг завийг тус ангийн ажиллагааны офицер, ахмад А.Энхжин албаны хүмүүст танилцуулж, тайлбарлав.

Ахмад А.Энхжин 2014 онд УБХИС-ийг цэргийн инженер мэргэжлээр дүүргээд тус ангидаа салааны захирагчаар ажлын гараагаа эхэлжээ. Тэрээр хамт олныхоо тухай "Манай анги Монгол Улсын хэмжээнд үйл ажиллагаа явуулдаг бөгөөд гүүр, ус гатлалтын тусламжийг олон аймгийн иргэдэд зүүллж ирсэн хамт олон. Үндсэн үүргийнхээ хажуугаар төмөр замын бүтээн байгуулалтад ч цөөнгүй алба хаагч маань оролцож байна. Энхийг дэмжих ажиллагаанд офицер, ахлагч, цэргийн гэрээт алба хаагчдын 80 гаруй хувь нь үүрэг гүйцэтгэсэн туршлагатай. Аливаа ажилд бүтээлчээр ханддаг эвсэг, найрсаг хөдөлмөрч хамт олон. Энэ жил бид сургалтын материаллаг баазыг дээшлүүлэхэд ихээхэн анхаарч олон ажил, арга хэмжээг зохион байгуулсан. Зэвсэглэл, техникийн бэлэн байдлыг хангах ажлыг ч мөн үе шаттайгаар хэрэгжүүлж байна" хэмээв. Цэгцтэй, тодорхой ярьдаг ахмад залуугаас усан саад гатлах болон шумбахад хэрэглэгддэг багаж хэрэгслийнх нь тухай тодруулахад "Ихэнх нь ЗХУ-ын үед үйлдвэрлэгдсэн багаж хэрэгслүүд. Гэхдээ үүрэг гүйцэтгэхэд түүртэй зүйлгүй, боломжтой" гэв.

**СУРГАЛТЫН МАТЕРИАЛЛАГ БААЗЫГ САЙЖРУУЛЖЭЭ**  
Тус ангийн захирагч, дэд хурандаа Ц.Батхүүгийн хэлснээр

усчин дайчид энэ жил сургалтын материаллаг баазыг дээшлүүлэх чиглэлд хэд хэдэн ажлыг өрнүүлсэн байна. Тухайлбал, Сургалтын төвөө төхөөрөмжлөн тохижуулж, спортын төвөө бүрэн шинэчилж, соёлын төв, буудлагын болон саадын зурвасууддаа засвар, шинэчлэл хийжээ. Мөн алба хаагчдын амьдрах

орчин нөхцөлийг сайжруулах хүрээнд офицер, ахлагчийн орон сууцнуудад их засвар оруулж, ая тухтай болгон өнгө төрхийг нь өөрчилсөн байна. Түүнчлэн хөгжмийн салаатай болж, ЗХЖШ-ын дарга болон Зэвсэгт хүчний Үлгэр жишээ, үлээвэр найрал хөгжмийнхний тусламж дэмжлэгээр хөгжмийн зэмсэгтэй болсон байна.

Цаашдаа хөгжмийн салаагаа байрлуулах байр болоод бусад бүтээн байгуулалтын ажлууд хүлээж байгаа хэмээн дэд хурандаа Ц.Батхүү онцолж байсан юм.

Үргэлжлүүлээд номын сан, цэргийн халуун ус, агуулахуудаар зочиллоо. Номын санчаар Ж.Дулмаа гэдэг эмэгтэй ажилладаг. Тэрээр тус ангид ажиллаад 24 жил болж байгаа гэнэ. Анх нягтлан бодогчоор ажиллаж байгаад 14 жилийн өмнөөс номын санчаар томилогджээ. Номын санд нь 1200 гаруй бүтээл байгаа бөгөөд бие бүрэлдэхүүний уншилтын тоо өндөр, сар бүр "Номтой нөхөрлөө" арга хэмжээг зохион байгуулдаг байна. Залуустай интернет орчноос биш номоос мэдлэг олж авахыг ч үргэлж уриалж, идэвхтэн уншигчдынхаа тоог нэмж ирсэн тухайгаа тэр хуучилна лээ.

Харин хангалтын нярав П.Цэнд цэргийн хүний гэргийн ёсоор нөхрөө дагаж олон аймаг дамжиж ажилласан эмэгтэй ажээ. Тэрээр байгалийн үзэсгэлэн төгөлдөр Хялганат тосгон болон ажилсаг бүтээлч хамт олноо магтаад "Зэвсэгт хүчний Жанжин штаб, Хуурай замын цэргийн командлалын удирдлагууд манай ангид ажиллаж, бидний ажил байдалтай танилцаж байгаад их баяртай байна. Цаг үеэ олж ирлээ. Ирэх жил 40 жилийнхээ ойтой золгох манай хамт олон бүтээлч ажлын ард хамтдаа гарах болно" гэлээ.

## САХИЛГА, ХАРИУЦЛАГАА БҮХ ТҮВШИНДЭЭ ДЭЭШЛҮҮЛ ГЭВ

Албаныхан томилолтын төгсгөлд тус ангийн бие бүрэлдэхүүнтэй уулзаж, Зэвсэгт хүчнээс хэрэгжүүлж байгаа ажил, арга хэмжээ, баримталж буй бодлогын талаар мэдээлэл хүргэв. Хошууч генерал Д.Ганзориг "Төмөр замын бүтээн байгуулалтад цөөнгүй алба хаагчид оролцож байгаа ч хүн, хүчээр дутлаа гэхгүйгээр ангидаа бүтээн байгуулалтын ажлыг өрнүүлж, сургалт бэлтгэлээ улам чамбайруулж буй т бүхнээр бахархаж байна. Ирэх жил орчин цагийн Зэвсэгт хүчний 100, тус ангийн түүхт 40 жилийн ой болно. Түүхт ойннуудаа угтаж олон ажил, арга хэмжээг зохион байгуулж явуулна гэдэгт итгэлтэй байна. Хамгийн гол нь сахилга, хариуцлагаа улам сайжруулж, үүрэг гүйцэтгэх чадвараа нэмэгдүүлэх сургалт, бэлтгэлүүдийг түлхүү явуулах хэрэгтэй. Та бүхэн бусад нэгтгэл, ангиудыг бодвол мод, модон бүтээгдэхүүнтэй ойрхон анги, хамт олон. Энэхүү боломжоо ашиглан орон нутгийн удирдлагуудтай нягт хамтран ажиллаарай. Бүтээлч, санаачилга, дэг журамтай газар ажил урагшилдаг учир цэргийн гэрээт албаны байлдагчаасаа эхлээд захирагч хүртлээ анги, байгууллагаа улам сайхан өнгө төрхтэй болгож, бэлэн байдал, бэлтгэлжилтээ дээшлүүлэхэд анхаар. Цэргийн энгийн гэлтгүй хичээ. Ингэхдээ хөдөлмөрийн аюулгүй байдлын зааварчилгааг ягштал мөрдөж ажилла" гэв.

Зэвсэгт хүчний Жанжин штабын дарга, хошууч генерал Д.Ганзориг, Зэвсэгт хүчний Хуурай замын цэргийн командлагч, бригадын генерал Б.Амгаланбаатар нарыг тус ангид ажиллах үеэр Булган аймгийн Хангал сумын Засаг дарга С.Ичинхорлоо ирж уулзсан бөгөөд тэрээр "Зэвсэгт хүчний 234 дүгээр анги нь орон нутагтаа дэмтэй, нийгмийн хариуцлагын хүрээнд олон ажилд хүн, хүчний тусламж үзүүлж ирсэн. Орон нутагтаа цэргийн албыг өөрсдөөрөө үйлэрлэж чаддаг хамт олон. 2017 оноос хойш жил бүрийн наадмын өмнө Төрийн далбааны өдрөөр цэргийн ёслолын жагсаалыг Булган аймагт зохион байгуулж байгаа. Бидний хувьд үйл ажиллагааг нь үргэлж дэмжиж, тусалж яваа" гэсэн юм.

Ахлах дэслэгч Д.БОЛОРМАА

ХҮНДЭТ ХАРУУЛ-65 ЖИЛ

# ХҮНДЭТ ХАРУУЛ ХҮНДТЭЙ АЛБА

Бүгд Найрамдах Монгол Ард Улсын Ардын Цэргийн жанжны тушаалаар 1955 оны 8 дугаар сарын 16-ны өдөр Жанжин Д.Сүхбаатарын нэрэмжит Цэргийн Ерөнхий сургуулийн жагсаал ангийн дарга, хошууч Жамсрангийн Ёндонг Улаанбаатар хотын комендантанд Хүндэт харуулын ротын даргаар, Цэргийн Ерөнхий сургуулийг төгссөн бага дэслэгч Дашдоржийн Бавуудорж, дэслэгч Гомбожавын Агваанжанцан, бага дэслэгч Өлзийтийн Хишгээ, дэслэгч Лхамсүрэнгийн Лхаяа, Батнасангийн Тавхай нарыг салааны захирагчаар томилсон байна.

Энэхүү түүхэн тушаал гарсан өдрөөс Зэвсэгт хүчний нүүр царай болсон Хүндэт харуулын үүрэг, зорилгыг Монгол Улсад айлчлан ирэх гадаад орнуудын Төрийн тэргүүн, Ерөнхий сайд, Батлан хамгаалахын сайд, Жанжин штабын дарга, Элчин сайдуудыг угтах, хүндэтгэлийн цэцэг өргөх, төрийн болон цэргийн ёслол, хүндэтгэлийн ажиллагааг гүйцэтгэх байнгын бүрэлдэхүүн гэж тодорхойлжээ. Хүндэт харуулын тусгай ротын үйл ажиллагаа бие даасан бүрэлдэхүүнтэйгээр явагдах эхлэл ийнхүү тавигдсанаар хүндэт харуулын тусгай рот нь дөрвөн салаатай, салаа тус бүр нь 30 хүнтэй, винтгоор зэвсэглэсэн, ротын дарга нь сэлэмтэй байжээ. Энэ үед Хүндэт харуулын хувцас нь битүү захтай китель, "кальфи"-тай хар өмд, шевро гутал, саравчтай малгай, суран бүс, цэрэг таван хошуу, "Ерөнхий цэрэг" гэсэн үсэгтэй сурагч мөрдэс, өвлийн улиралд будёновк гэдэг шовгор оройтой бор цэмбэн малгай, шинельтэй байжээ.

1955 оны намар манай улсад албан ёсны айлчлал хийсэн БНАГУ-ын Төрийн зөвлөлийн дарга Отта Гортвальдыг Буянт-Ухаагийн нисэх онгоцны буудалд төрийн ёслол, хүндэтгэл үйлдэн хүлээн авснаар Хүндэт харуулын тусгай ротын түүхийн анхны хуудас нээгдсэн юм. "Энэхүү ёслолын үүргийг хугацаат цэргийн албанд ирээд хоёрхон сар болсон шинэ дайчдаар

1955 онд Ж.Ёндон агсан хүндэт харуулын даргаар томилогдсоноос хойш 1956-1957 онд Т.Туваанжав, 1957-1958 онд М.Лувсаншарав, 1960-1962 онд Т.Баатар, 1962-1964 онд Н.Дашцэрэн, 1964-1967 онд Р.Гүнчин-Иш, 1967-1968 онд Ц.Бямбасүрэн, 1968-1969 онд Б.Бат-Очир, 1969-1971 онд Г.Намсрай, 1971-1974 онд Б.Түмэн, 1974-1977 онд Б.Дашдондог, 1977-1978 онд Д.Пүрэв, 1977-1978 онд М.Нармандах, 1978-1981 онд Д.Ганбагана, 1981-1983 онд Ж.Дүүрэнжаргал, 1983-1986 онд Г.Өнөрсайхан, 1986-1989 онд Д.Зоригт, 1989-1991 онд Г.Батсайхан, 1991-1993 онд Г.Булган, 1993-1994 онд Б.Мөнхгэрэл, 1994-1999 онд С.Цэрэндорж, 1999-2002 онд Л.Онцгойбаяр, 2002-2005 онд Б.Хаш-Эрдэнэ, 2004-2005 онд А.Төгс-Эрдэнэ, 2005-2014 онд С.Ариунболд, 2014-2015 онд Э.Билэгсайхан гэсэн эрхмүүд түүхэн цаг үеийг өртөөлөн алба, үүргээ нэр төртэйгөөр биелүүлсэн юм. Харин 2015 оноос хошууч Ж.Баярцогт Хүндэт харуулын даргаар томилогдон үүрэг гүйцэтгэж байна.

бичигдсэн хэд хэдэн төрийн ёслолыг гүйцэтгэсэн байдаг. Олон улсын болон коммунист ажилчны хөдөлгөөний нэрт зүтгэлтэн, Зөвлөлт Холбоот Улсын Коминтерн намын Төв хорооны Ерөнхий нарийн бичгийн дарга Л.И.Брежнев даргыг хүлээн авах төрийн ёслолд Хүндэт харуулын тусгай ротын бие бүрэлдэхүүнээс гадна Жанжин штабын офицеруудын нэг рот зохион байгуулан оролцуулж, зочдыг угтан авах ба үдэх ёслолын ажиллагааг амжилттай зохион байгуулжээ.

1970-аад оны эхэн үе гэхэд Хүндэт харуулын тусгай ротын нэр хүнд эрс өсөж, улс орны хэмжээнд түүхт ой, онцгой баяр ёслолын арга хэмжээ нэмэгдсэнтэй холбогдон төрийн болон цэргийн бусад ёслолын ажиллагаа нь байнгын бэлтгэл, сургуулийг шаардах болжээ. Ардын хувьсгалын ялалтын 50, БНМАУ-ыг тунхагласны 50 жил, Халхын голын байлдааны ялалтын 45, 50 жилийн ойн томоохон ёслолууд болж, хүндэт харуулын тусгай ротын бие бүрэлдэхүүн голлох үүрэгтэйгээр оролцсон ажээ. 1970-1980 оны хооронд хүндэт харуулын тусгай ротын бие бүрэлдэхүүн төрийн болон цэргийн ёслол хүндэтгэлийн үйл ажиллагааг 554 удаа гүйцэтгэсэн нь үүнийг тод гэрчилнэ. Улс орны хөгжлийн шинэ шатанд хамгийн чухал үүрэг гүйцэтгэдэг нийгмийн харилцаа бол гадаад харилцаа байдаг. Гадаад харилцаа өргөжин тэлэхийн хэрээр манай улсад айлчлан ирэх гаднын


болгожээ. Манай улсад ардчилсан хувьсгал гарч, нийгмийн тогтолцоог өөрчлөн шинэчлэх явцад Засгийн газар, яам, агентлагуудын үндсэн үүрэг, зорилтууд шинэчлэгдэж, өөрчлөлтийг хаа сайгүй хийж байсан эргэлтийн гэж болох цаг үед Зэвсэгт хүчнийг тогтвортой байлгах, цэргийн шинэчлэлийг эрчимжүүлэх үйл явц нэгэн зэрэг эхэлсэн билээ.

Төрийн болон цэргийн ёслол хүндэтгэлийн ажиллагаанд уламжлал, ёс заншлаа дээдэлсэн шинэ хандлага гарч эхэлсэн юм. Үзэл сурталжсан нийгмээс чөлөөт ардчилсан, хүний эрх, эрх чөлөөг дээдэлсэн нийгэм рүү шилжих явцад үндэстний бүхнээ ил гаргах, мартагдсан ёс заншлыг сэргээх нь төр, засгийн тогтоол, шийдвэрээр хэрэгжиж байсан юм. Монгол Улсын төрийн үйл хэрэг мандан бадрахын бэлгэдэл нь Есөн хөлт цагаан туг, сүлдэнд шингэснийг сэргээн мандуулах ажил эрчимтэй өрнөв. Чингис хаан Их Монгол Улсын тулгар төрийг байгуулж, есөн хөлт, есөн манжлагат төрийн Их цагаан тугийг босгон дээдэлж олон зуун жилээр даган мөрдөж байсан ёс жаягийг сэргээн мандуулах нь ардчилсан Монгол Улсын төрийн үйл хэрэг байлаа. Монгол Улс түүх, соёлоо сэргээн мандуулж, 1992 онд баталсан шинэ Үндсэн хуульдаа "Есөн хөлт Их цагаан туг нь Монгол Улсын Төрийн туг мөн" гэж заасан байдаг.

Үндсэн хуулийн зүйл, заалтын дагуу 1992 оны 4 дүгээр сарын 28-ны өдөр "Монгол Улсын Бүх цэргийн



1990 оны наадмын нээлт



Төрийн ёслолын цэргийн цагаан тугтай болсон нь



1991 оны шөнийн парад

гүйцэтгүүлсэн юм" гэж БХЯ-ны сайд агсан хурандаа генерал Ж.Ёндон дурсан бичиж үлдээсэн байна.

Монгол Улс 1961 онд НҮБ-д бүрэн эрхт гишүүнээр элссэн нь гадаад харилцаа улам өргөжин тэлж, манай оронд гадаад орнуудаас суух элчин сайдын тоо нэмэгдэж, төр, засгийн хэмжээний ёслолын тоо өссөнөөр Хүндэт харуулын тусгай ротын ачаалал ихсэх болсон байна. 1955-1956 онд төрийн дээд хэмжээний айлчлал дөрөв, элчин сайдын итгэмжлэх жуух бичиг барих ёслол 21, хүндэтгэлийн цэцэг өргөх ёслол 16, нийт 41 ёслолыг үйлдэж байсан бол энэ тоо 1956-1960 онд 153 болж, гурав дахин нэмэгджээ. Энэхүү өсөн нэмэгдэж байгаа үзүүлэлт нь Хүндэт харуулын тусгай ротын бие бүрэлдэхүүний бэлэн байдал, төрийн ёслол хүндэтгэлийг гүйцэтгэх үүрэг хариуцлагыг улам нэмэгдүүлж, тэдний нэр хүндийг олон улсын тавцанд гарахад ихээхэн хөшүүрэг болсон юм.

1960-аад оны дунд үе гэхэд Хүндэт харуулын тусгай ротын үйл ажиллагаа бүрэн жигдэрч, төрийн болон цэргийн ёслол хүндэтгэлийн ажиллагааг мэргэжлийн өндөр түвшинд гүйцэтгэж, дээд байгууллагаас удаа дараа сайшаагдаж байсны дотор ротын төдийгүй манай улсын түүхэнд

зочид, төлөөлөгчдийн тоо нэмэгдэх нь ойлгомжтой. Энэ хэрээр төрийн ёслолын үүрэг, оролцоо улам нэмэгдэнэ гэсэн үг. Нөгөөтэйгүүр цаг хугацааны уртад улс орны түүх, хөгжил цэцэглэлтэд түүхэн гавьяатай тэмдэглэлт ой, баярын өдрүүд нэмэгдсэн зэрэг нийгмийн хөгжлийн үйл явцыг дагаад төрийн ёслол, хүндэтгэлийн ажиллагаа өмнөх он жилүүдээс тоо, чанарын хувьд олширсон нь Хүндэт харуулын тусгай ротын ачааллыг нэмэгдүүлжээ.

1980 онд Хүндэт харуулын тусгай ротын бүрэлдэхүүнд орон тооны нөхөн хангалт хийж нэг салааг нэмж зохион байгуулснаар тус рот таван салаатай болжээ. Үүний дараа 1980-1990 оны хооронд төрийн дээд хэмжээний айлчлал 25, элчин сайдын итгэмжлэх жуух бичиг барих хүндэтгэл 147, цэцэг өргөх болон цэргийн бусад ёслолын ажиллагааг 558 удаа гүйцэтгэжээ. Эдгээр он жилүүд нь Зэвсэгт хүчний хөгжлийн оргил үе байсантай давхцаж байгаа тул Хүндэт харуулын тусгай ротын хувьд ч хөгжлийн нэгэн өндөрлөг нь байсан юм.

1986 онд Хүндэт харуулын тусгай ротыг БХЯ-ны сайдын тушаалаар МАА-ийн Хүндэт харуулын батальон болгон өргөтгөн зохион байгуулж, гурван роттой

Их хар сүлд, цэргийн ангийн байлдааны туг, Төрийн ёслолын цэргийн цагаан туг гардуулах тухай" Монгол Улсын Ерөнхийлөгчийн шийдвэр гарч, туурга тусгаар Монгол Улсын энхжин мандаж, мөнхжин оршихын бэлгэдэл Есөн хөлт Их цагаан тугийн элч болсон төрийн ёслолын Цэргийн цагаан тугийг залах ёслолыг уламжлан сэргээжээ. Уг шийдвэрт "Монгол Улсын Бүх цэргийн Их хар сүлдийг Батлан хамгаалах яаманд, Байлдааны тугийг цэргийн нэгтгэл, ангиудад, Төрийн ёслолын цэргийн цагаан тугийг 032 дугаар ангид тус тус гардуулсугай" гэж заасан байна.

1992 оны 5 дугаар сарын 1-ний өдөр Монгол Улсын Ерөнхийлөгчийн 63 тоот зарлигаар Монгол Улсын Төрийн ёслолын цэргийн цагаан туг хүлээн авах ёслолын ажиллагаа тус ангийн жагсаалын талбайд болж, ангийн захирагч хурандаа Д.Цогтбаатар уг тугийг баяр ёслолын байдалтай гардан авч, ангийн бие бүрэлдэхүүн анх удаа Төрийн ёслолын цэргийн цагаан тугийн дор нэгдэн жагсаж, хүндэтгэл үзүүлжээ.

Өнө эртний түүхэн уламжлалтай төрт ёс сэргэж, үндэсний бахархлаа дээдэлсэн Монголын ард түмэн Есөн хөлт Их цагаан тугаа дээдлэн цэнгүүлэх, залах зан үйл, ёслолын

ажиллагааг түүхэн тэмдэглэлт үйл явдлуудаар үйлдэж, Монгол Улсын Төрийн ёслолын албанаас гаргасан "Монгол Улсын Есөн хөлт Төрийн тугийг Төрийн ордонд залж байрлуулах" журмын дагуу Хүндэт харуулын тусгай ротын бие бүрэлдэхүүн энэхүү ёслолын ажиллагааг гүйцэтгэсээр байгаа юм.

1994 онд Монгол Улсын Ерөнхийлөгчийн 67 дугаар зарлигаар "Монгол Улсын Төрийн тугийг Төрийн ордонд залж байрлуулах тухай" журмыг албан ёсоор батлан өнөөг хүртэл мөрдөн ажиллаж, Зэвсэгт хүчний 032 дугаар ангийн бие бүрэлдэхүүн нэр төртэйгөөр гүйцэтгэж байна.

Энэхүү журмын хоёр, гуравдугаар зүйлд "Төрийн тугийг хүндэтгэн залах ажиллагааг

төрийн хонжин, тэргүүн тугч, тугчид гүйцэтгэх бөгөөд Төрийн ёслолын торгон цэрэг хамгаална. Төрийн тугийг хүндэтгэн залах үед Төрийн хонжин энэ ажиллагаанд оролцож байгаа торгон цэргийг захирна. Бүгд 32 морьтон оролцоно" хэмээн заажээ.

1995 оны 6 дугаар сарын 13-ны өдөр Бүх цэргийн их Хар сүлдийг анх удаа Хэнтий нурууны салбар Бурхан халдун ууланд цэнгүүлэх зан үйлт ёслолын ажиллагааг гүйцэтгэжээ. Энэ ёслолоос хойш Бүх цэргийн Их хар сүлдийг тайх, цэнгүүлэх ёслол хоёр жил тутамд нэг удаа болдог уламжлал тогтсон юм.

"Хүндэт харуул" ТББ-ын гүйцэтгэх захирал, Хүндэт харуулын 23 дахь дарга, бэлтгэл дэд хурандаа С.ЦЭРЭНДОРЖ



ЧӨЛӨӨЛӨХ ДАЙНЫ ЯЛАЛТЫН 75 ЖИЛ-АХМАД ДАЙЧДЫН СЭТГЭГДЭЛ

# ДАЙНЫ ЖИЛИЙН ЦЭРЭГ ЯВСАН МИНИЙ ААВ



Аав, хүү хоёр. 1977 он

Миний аав Түмэн-Өлзийн Базаррагчаа нь 1922 онд Говь-Алтай аймгийн Эрдэнэ суманд төрсөн. Тэрээр айлын ганц хүү бөгөөд 18 настайдаа цэргийн албанд мордсон юм. Аав маань Завханы Улиастай, Дорнодын Баянтүмэний 5 дугаар дивизэд жагсаалын цэргээр томилогдож, байлдагч цолтой алба хаасан.

Аав маань эгэл жирийн цэрэг байсан ба Чөлөөлөх дайныг эхнээс нь дуустал оролцсон түүхтэй. Цаг хугацаа улиран өнгөрөх тутам бид Чөлөөлөх дайнд монголын ард түмэн, түүний дотор Монгол Ардын Хувьсгалт Цэрэг албан ёсоор оролцож, ялалт байгуулсан тухайд, энэхүү мөнхийн гавьяат үйлсийг умартах, түүгээр ч барахгүй мартагнах, ач холбогдлыг

нь алдагдуулах байдал гарч байгаад ахмад дайчны хувьд сэтгэл дундуур явдаг юм.

Өөрөөр хэлбэл, Монголын Үндэсний Олон Нийтийн телевизээр цэргийн түүхийн цөөн тооны эрдэмтэд дайны ялалтын тухай ярилцлага хийж буй товчхон нэвтрүүлгээс өөр зүйлгүй өнгөрүүлэх гэж байгаа нь тун харамсалтай.

Аав минь ярихдаа, 5 дугаар морьт дивиз Долоннуур, Жэхэ хот, Шар, Хөх мөрнийг гатлан, Зүүн хойд Хятад, Өвөр Монголын нутгийг японы милитаристуудаас чөлөөлж, Хятадын ядарсан ард түмэнд эрх чөлөө, тусгаар тогтнолоо олоход нь үнэтэй хувь нэмэр оруулсныг дурсан ярьдаг байлаа.

Эх орны дайны ялалтын 75 жилийн ойг Орос улс, түүний ард түмэн дэлхий нийтийг хамарсан цар тахлын хүнд хэцүү цаг үед эрүүл ахуй, аюулгүй байдлын арга хэмжээг өндөр шатанд хэрэгжүүлэн дэлхийн бусад улс, үндэстэн, тэдгээрийн Зэвсэгт хүчний дайчдын хамтаар өргөн хэмжээнд тэмдэглэн өнгөрүүлснийг хараад бахархах сэтгэл төрсөн.

Би ахмад дайчин, бэлтгэл офицер, үе дамжсан цэргийн хүн болохоороо энэхүү ялалтын ойгоор өөрийн ааваараа бахархан, омогшиж, дурсан санаж явна. Тэрхүү Чөлөөлөх дайны ялалт, цаг хугацааны хувьд улам бүр алсрах тутам миний сэтгэл зүрхэнд улам тодрон, гүн сэтгэгдэл төрүүлсээр байх болжээ.

Чөлөөлөх дайны ялалтыг авч ирсэн ахмадууд та нартаа урт удаан насалж, энх тунх, эрүүл саруул байхын өлзийтэй ерөөлийг өргөн дэвшүүлж байна.

Бэлтгэл дэд хурандаа Б.ЦЭН-ОЙДОВ



Зүүн гар талаас эгч Д.Лхамсүрэн, хүү Б.Цэен-Ойдов, аав Т.Базаррагчаа, эгч Б.Дэнсмаа, ээж Б.Долгорсүрэн

# БАЙЛДААНЫ МЭДЭЭГ РАДИО ХОЛБОО Л ХҮРТЭДЭТ БАЙЖЭЭ

Миний аав Намжилын Мягмарсүрэн нь 1914 онд одоогийн Архангай аймгийн Чулуут сумын Хүрмийн гол хэмээх газар төрсөн бөгөөд Монгол Улсын харилцаа холбоог хөгжүүлэх үйлсэд жинтэй хувь нэмэр оруулан бахархал дүүрэн зүтгэсэн арвин намтартай ахмад холбоочин байсан юм. Бид аавынхаа энгэрт гялалзах "Алтан гадас" одон, Хөдөлмөрийн хүндэт медаль, Ардын хувьсгалын ойн медалиудаар нь ямагт бахархаж ирсэн бөгөөд түүний "Онц холбоочин" цолыг нь ихэд хүндэлдэг байлаа. Аав маань 1933 оны 10 дугаар сард Цэргийн Ерөнхий Сургуулийг цэргийн холбооны мэргэжлээр төгсөж хэсэг нөхдийн хамт Төв харилцаа холбоонд томилогдон ажилласан юм.

Тэрбээр Халхын голын байлдаан болон Чөлөөлөх дайны эхлэл, өрнөл, үйл явц, баатарлаг ялалтын тухай мэдээг эх орон даяар нэвтрүүлж байсан тухайгаа өөрийн дурсамждаа "1939 онд нэгэн том хашаанд орос ах

байсан ба хүлээн авах төв нь одоогийн Төмөр замын төв буудалд байрладаг байсан ба Хүлээн авах станцын ахлагч нь би байж билээ. Халхын голын байлдааны тухайд гэвэл дайн эхлэхээс дуустал гэртээ харилгүйгээр хүлээн авах станц дээрээ сууж, Зөвлөлтийн мэргэжилтнүүдийн хамт ажилладаг байв. Тэр үеийн Радио нэвтрүүлэх төв станц нь хэдэн давхар харуул манаатай байж билээ" хэмээсэн тэмдэглэл нь бидэнд хадгалагджээ.

Ер нь аль ч цагт харилцаа холбоо хэчнээн чухал байдгийн нэгэн жишээ нь тэр ажээ. Хамгийн гол нь дайны үеийн мэдээ, ард түмний сэтгэл бодол зөвхөн радио холбоогоор л дамжин олон нийтэд тугэн хүрдэг байсан. Тэр үед одоогийнх шиг орон хэвлэл мэдээллийн хэрэгсэл байсан биш дээ. Хүмүүс радиог л сонсож мэдээлэл авдаг байлаа даа" гэсэн аавынхаа дурсамжийг өдгөө бид дурсан сууна.

Энд тодотгоход Халхын голын байлдааны болон Чөлөөлөх дайны

маршал Х.Чойбалсан Радио хороон дээр ирсэн бөгөөд намайг "Бүх аппарат, техник хэрэгсэл бэлэн" хэмээн илтгэсний дараа холбоогоор "Өвөр Монголын авхай нараа! Та нарыг Японы эзэрхэг түрэмгийчүүдээс салгахын тулд Бүрэн эрхт Монгол Улс Японы эсрэг дайн зарлалаа" гэж хэлсэн юм. Тухайн үед маршалын царай нь тун баргар байж билээ хэмээн Монголын холбоочдын хэвлэл болох "Дуудлага" сонины 1995 оны 4 дүгээр сарын 2 дахь дугаарт хэвлэжээ. Мөн энэ тухай "Туулсан замаа эргэн дурсахуй" (1996 он) номын 126-128 хуудсанд бичигдсэн байдаг юм.

Мөн "Намайг Чөлөөлөх дайны үед радио холбоонд хэлтсийн даргаар ажиллаж байх үед дайны үеийн холбоо гэдэг энгийн холбоотой зүйрлэхийн аргагүй хүнд байсан. Дайн, байлдааны үйл явц, өрнөл, ялалт, амжилтын тухай олон түмэнд мэдээлэх ажил, үүрэг нь зөвхөн холбооныхонд л оногдоно. Тэрхүү үүрэг манай хамт олонд болон надад биечлэн тохоогддог байсан ба бид ч энэхүү үүргээ нэр төртэй биелүүлсэн юм. Тиймээс ч дайнд явж, дайчин алдраа цуурайтуулсан баатрууд шиг цээжээ хангалзуулах шахам явцгааж билээ" гэж аав минь бахархал дүүрэн өгүүлдэг. Тэр бүхнийг нь аавын энгэрт гялалзах Халхын голын байлдааны ялалтын 35 жилийн ойн медаль, "Бид ялав" медаль, Милитарист Японыг ялсны 30 жилийн ойн медаль болон Жуковын медалиуд нь тод томруун илэрхийлдэг юм.

Энэ бүгдээс дүгнэхэд аав минь дайн, байлдааны галын шугамд биеэр оролцож, дайсны эсрэг буу барин дарийн утаа үнэртэж яваагүй ч фронтын ар талд цэргийн дүрэмт хувцас өмсөж эх орныхоо эрх чөлөө, тусгаар тогтнолын төлөө өндөр үүрэг хариуцлага хүлээж, тэрхүү үүргээ нэр төртэй биелүүлж явсан нэгэн юм.

Халхын голын байлдаанаас хойш буюу 1942 онд МАХН-ын Төв хорооны шийдвэрээр "МОНЦАМЭ"-д МАХН-ын Төв хорооны ухуулан боловсруулах хэлтсийн харьяанд радио, телевизийн нэвтрүүлгийн тасгийг нээн ажиллуулахад ахлагчаар нь аав маань томилогдон ажиллаж, улмаар Монгол Улсад радио холбоог байгуулах үед техник, уран сайхны хэлтсийн даргаар ажиллаж байсан юм. Тэрчлэн Төв шуудангийн дарга, Нийслэлийн Налайх дүүрэг, Төв аймгийн холбооны даргын өндөр хариуцлагатай албан тушаалд ажиллаж байгаад гавьяаныхаа амралтад гарсан. Аав "МОНЦАМЭ"-гийн анхны монгол дарга бөгөөд өөрийн эх орны харилцаа холбооны салбарт он удаан жил тасралтгүй ажилласан ахмад холбоочин бөгөөд энэ л салбарынхаа

амжилт ололт, үйл ажиллагааны талаар олон арван шүлэг, дуулалт жүжиг, магтаал, найраглал бичиж өөрийн авьяас билгээ олны хүртээл болгож байлаа.

Тэр бээр "Дуутай ширүүн бороо" дуугаараа зохиолчдын дунд танигдсан нэгэн бөгөөд эл дууг Ардын жүжигчин Л.Цогзолмаа гуай уран яруу дуулсан байдаг. Мөн охин надад зориулан "Миний охин хөөрхөн", ээжид минь зориулан "Сайхан" хэмээх шүлгүүд бичсэн нь өдгөө дуу болон дуулагдсаар байна.



Зураг дээр өвөр эгнээнд зүүн гар талаас Н.Мягмарсүрэн, Б.Одончимэг, Б.Цэнд-Аюуш, арын эгнээнд М.Баттулга, М.Хажидмаа

нартайгаа хамт ажиллах хувь завшаан надад тохиосон юм шүү дээ. Дайн, байлдааны хэцүү үед Оросууд 5-6 хүн, бидний монголчууд ч мөн төдий багцааны хүн ажилладаг байлаа. Энэ үе бол манай оронд радио холбоо үүсэн хөгжиж эхэлж байсан цаг үе юм. Радио нэвтрүүлэх төв станц Улаан хуарангийн "Гурван өндөр"-ийн хавьд

үйл явц, ялалтын мэдээ зэргийг зөвхөн радиогоор дамжуулдаг байсны дотор Бүх цэргийн жанжин, маршал Х.Чойбалсангаас 1945 оны 8 дугаар сарын 10-ны өдөр милитарист японд шударга дайн зарласан тухай мэдээг нэвтрүүлж байснаа мартдаггүй юм хэмээн аав минь дурссан. Энэ тухайд, 1945 оны 8 дугаар сарын 10-ны өглөө

Бидний аавын бичсэн "Холбооны анхны дуу", "Радио-энх тайвны холбоочид", "Ирсэн захидал" дуу, "Нутгийн малчид", "Тарьсан модны гомдол", "Нам бидний наран" хэмээх харилцаа дуу, "Хорин хоёр жилийн ойд", "Майн нэгний ойд", "Ленин таны сургаал", "Ялалтад мөнх", "Гэтэл", "Харилцаа холбооны тухай" зэрэг ерөөлийг бичиж үлдээсэн юм.

Аав маань Б.Цэнд-Аюуштай гэр бүл болж охин М.Алтанцэцэг, М.Хажидмааг төрүүлж өсгөсөн бөгөөд миний хүү дэслэгч Б.Одмандах өвөөгийнхөө үйл хэргийг залгамжлан Зэвсэгт хүчний 311 дүгээр ангийн Эрүүл мэндийн төвийн их эмчээр ажиллан эх орныхоо тусгаар тогтнол, эрх чөлөөний төлөө эр цэргийн тангараг өргөж, хос тангарагтай албанд зүтгэж явна. Мөнх тэнгэрийн орноос өөрийнх нь дутуу үлдээсэн үйлийг гүйцээхээр сэтгэл шулуудсан ээ хүүгээрээ аав маань бахархаж буй биз ээ.

"Ирээдүй" цогцолбор сургуулийн гадаад хэлний багш АБТА, докторант М.ХАЖИДМАА

